

ГИТА МАХАТМЬЯ БУЮУ ГИТАГИЙН МАГТУУ

ӨМНӨХ ҮГ

Махабхаратад (Шанти-парва, 348.51-52) Гитагийн түүхийн талаар өгүүлсэн дараахь мөрүүд байдаг:

*трета-югадау ча тато вивасван манаве дадау
мануш ча лока-бхрити-артхам сутаеткивакаведадау
икшвакуна ча катхито вьянья локан авастхитах*

“Бүхний Дээдтэй холбогдсон холбоо харьцааны тухай энэхүү эрдэм ухааныг Трета юга-ын эхэнд Вивасван Мануд дамжуулан хүртээсэн билээ. Хүн төрөлхтний өвөг эцэг болох Ману түүнийг Рамачандра Бурханы мэндлэн тодорсон Рагхугийн удмын өвөг дээдэс хийгээд газар дэлхийн хаан болох өөрийн хүү Махаража Икшвакуд дамжуулан сургасан болой”. Иймд Бхагавад Гитаг хүн төрөлхтөн Махаража Икшвакугийн хаанчлалын цаг үеэс эхлэн хүртжээ.

Нийт 432 000 жил үргэлжлэх Кали юга эхэлснээс хойш эдүгээг хүртэл 5000 жил өнгөрсөн. Энэ цаг үеийн өмнө Двапара юга (800 000 жил үргэлжилсэн), мөн түүний өмнө Трета юга (1 200 000 жил үргэлжилсэн) болж өнгөрсөн. Иймээс Ману нь Бхагавад Гитаг энэ гариг-дэлхийн хаан, өөрийн хүү хийгээд шавь болох Махаража Икшвакуд ойролцоогоор 2 005 000 жилийн өмнө номложээ. Одоогийн энэ Манугийн амьдралын хугацаа 305 300 000 жил үргэлжлэх бөгөөд түүнээс одоог хүртэл 120 400 000 жил нь улиран одсон билээ. Үүнээс үзэхэд, Бурхан Гитаг энэхүү Мануг төрөхөөс өмнө Өөрийн шавь-нарны бурхан Вивасванд айлдсан бол Гита нь барагцаалбал наад зах нь 120 400 000 жилийн өмнө, харин хүний нийгэмд хоёр сая жилийн өмнөө номлогджээ. Ингээд Бурхан Бхагавад Гитаг 5000 жилийн өмнө Аржунад дахин айлдсан байна. Гитагаас өөрөөс нь болон түүнийг айлдсан Бурхан Кришнагийн айлдвараас үзэхэд Гитагийн түүхийн ерөнхий байдал ийнхүү харагдах ажээ.

Нарны бурхан Вивасван нь *кшатрия* байсан хийгээд *сурья-вамша кшатрия* буюу нарны бурхны үр удам болцгоох бүх *кшатриянуудын* өвөг болох учир түүнд Бхагавад Гитаг айлджээ. Бхагавад Гитаг Бурханы Дээд Бодьгал айлдсан учир тэрээр Ведүүдийн нэгэн адил жинхэнэ эх сурвалж мөн тул түүнийг *анаурушея* буюу хүний хүч чадавхи хир хэмжээнээс илүү дээд мэдлэг хэмээдэг билээ. Ведийн сургаалыг хэн нэгэн хүний ухааны тайлбаргүйгээр, байгаа чигээр нь хүлээн авч хүртэх ёстой байдгийн адил Гитаг ч мөн материаллаг тайлбаргүйгээр хүлээн авах хэрэгтэй. Материаллаг их мэдэгч нар Гитагийн талаар өөр өөрсдийнхөөрөө цэцэрхэн байх боловч тэдгээр нь үнэн хэрэгтээ анх айлдсан төрх байдлаараа байгаа Бхагавад Гита биш юм. Иймээс Бхагавад Гитаг анх айлдсан төрх байдлаар нь буюу энд тайлбарлаж байгаачлан, Бурхан эхлээд нарны бурханд, нарны бурхан өөрийн хүү Мануд, Ману өөрийн хүү Икшвакуд номлож

сургасан шиг, өөрөөр хэлбэл багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээгээр дамжуулан хүлээн авч хүртэх ёстой.

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын
“Бхагавад гита анх айлдсан төрхөөрөө” 4.1-ийн тайлбараас.

“Шримад Бхагавад гита”-гийн Нэгдгээр Бүлгийн магтуу

Парвати хэлсэн нь: “Хайрт нөхөр минь ээ, Та бүхий л трансцендент үнэнийг бүрнээ мэдэх билээ. Таны өршөөл ивгээлээр би Дээд Бурханы Бодгаль- Бурхан Кришнагийн тухай сонссон. Ай, ивээлт Эзэн минь ээ, харин одоо би Танаас “Шримад Бхагавад гита”-ийн суу алдрын талаар сонсохыг хүсэж байна. Энэ түүхийг нэгэнтээ Бурхан Кришна Өөрөө айлдсан хийгээд үүнийг сонссон хүн бүр Бурхан Кришнад чин бишрэлээр үйлчлэн зүтгэх чин сүсэг бишрэлийг өөртөө хөгжүүлдэг”.

Шива Тэнгэр хариу айлдсан нь: “Би вээр бие нь хар бараан борооны үүл мэт өнгөтэй, жигүүртний хаан Гарудыг унаа болгон хөлөглөдөг, мянган тэргүүнт Ананта-Шеша могойн дээр залран байх суу алдарт нь хэмжээ хязгаар үгүй Бурхан Вишнуд мөнхөд мөргөн залбирнам ”.

Миний хайрт Парвати минь ээ, нэгэнтээ Вишну Бурхан айхтар хүчит шулам Мураг даран устгаад Ананта-Шеша дээр тайван амарч байлаа. Тэр цагт бүхий л орчлонд аз хийморийг бэлэглэгч Шри Лакшми гүн хүндэтгэлтэйгээр Түүнээс: “Бхагаван минь ээ, Та бүхий л орчлон ертөнцийг удирдан залдаг хийгээд тогтоон барьж байдаг билээ. Гэвч энэхүү сүүн далай дээр Та нэг л сэтгэл дундуур мэт нойрсон байх юм. Үүний учир юунд байна вэ” хэмээн сонирхон асуув.

Вишну Бурхан хариу айлдсан нь: “Ай хайрт Лакшми минь ээ, Би унтаагүй байна. Харин миний эрчим хүч хэрхэн гайхалтайгаар ажилладаг болохыг ажиглан харж байна. Энэ Өөрийн гайхамшигт эрч хүчний туслалцаатайгаар Би бүгдийг удирдан залдаг хэдий ч Өөрөө түүнээс ангид оршдог билээ. Аугаа их чин бишрэлтэн, йогч нар нь Миний бурханлаг илрэлийг дурсан санахын хирээр үхэх, төрөхийн тойргоос ангижран гарч мөнхийн, хоёрдмол байдлаас ангид Миний трансцендент мөн чанарт хүрдэг юм”.

Лакшми хэлсэн нь: “Ай Бүгдийг удирдан залуурдагч Та минь ээ! Та вээр аугаа их йогчдын зорилго. Таны оролцоогүйгээр юу ч хийгдэж үл чадах билээ. Чингэвч Та бол бие даан тусгаар оршигч. Та бол материаллаг орчлонгийн бүтээл, бүтээлийг тогтоон барихуй хийгээд устгалт сөнөөлтийн шалтгаан. Тиймд Та өөрөө энд хэвтээд түүнийг ажиглан харж байх тэрхүү дур татам, агуу гайхалтай эрч хүч тань хэрхэн үйлчилдэгийг айлдаж хайрлана уу” хэмээв.

“Хайрт Лакшми минь ээ, Миний үлэмж олон эрч хүчнүүдийн үйлчлэл болон мөн хэрхэн үхэх, төрөхийн гав гинжнээс салан ангижирч болохыг зөвхөн Надад үйлчлэн зүтгэх дур сонирхолтой, ухаан бодол нь цэвэр хүн л ухааран ойлгож чадах билээ. Энэхүү трансцендент эрдэм мэдлэгийг “Шримад Бхагавад гита”-д бүрэн дүүрэн тайлбарласан ”.

Лакшми асуусан нь:”Ай Бурхан минь ээ, хэрэв Та Өөрөө Өөрийнхөө эрч хүчний үйлчлэл нөлөөг гайхан алмайрч түүний хязгаарыг хэмжих гэж оролдож байхад “Бхагавад гита” хэрхэн яаж Таны хязгааргүй эрч хүчийг өгүүлэн тайлбарлаж чадахсан билээ? Яаж түүнийг даван туулж, хэрхэн яаж тарнсцендент ахуйд хүрэх билээ?”.

Бурхан Вишну хариу айлдсан нь: “Би вээр Өөрөө “Бхагавад гита” дүрээр илрэн тодорсон билээ. Түүний эхний таван бүлэг нь Миний таван Толгой, дараагийн арван бүлэг нь Миний арван Гар, харин арван зургаадугаар бүлэг нь Миний Ходоод хийгээд харин сүүлчийн хоёр бүлэг нь Миний бадамлянхуа өлмий билээ. Чухамхүү чингэж “Бхагавад гита”-ын трансцендент шүтээнийг ойлгох хэрэгтэй. “Бхагавад гита” бүхий л нүгэл хилэнцийг устган арилгадаг. Ухаалаг хүн өдөр бүр нэг бүлгийг эсвэл нэг шлокийг /шүлэг/, эсвэл шлокийн хагасыг, эсвэл бүл шлокийн дөрөвний нэг хэсгийг өөрт сонсогдохуйц дуудан уншсанаар Сушхармын хүрсэн тэр амжилтад хүрч чадна”.

Лакшми асуусан нь: “Сушхарма гэж хэн юм бэ? Тэр нийгмийн ямар анги давхаргын хүн бэ? Тэр ямар амжилтанд хүрсэн юм бол?” хэмээв.

“Хайрт Лакшми минь ээ, Сушхарма бол хамгийн адгийн бузар муухай, нүгэлт нэгэн байсан юм. Тэрээр хэдий брахманы гэр бүлд төрсөн ч түүний гэр бүлд ведийн эрдэм ухаан үгүй байлаа. Бусдад зовлон, хорлолыг учруулснаар түүний сэтгэл нь ханадаг байв. Тэр хэзээ ч Миний Нэрийг давтан уншиж байгаагүй бөгөөд буян үйлдэж байсангүй, зочин гийчинг ч хүлээн авч байсангүй. Чухамдаа тэрээр хэзээ ч таатай сайн үйлийг үйлдэж байгаагүй юм. Өөрийн хэрэгцээг хангахын тулд тэр навч түүж түүнийгээ зах дээр аваачин худалддаг байв. Түүний гол жаргал цэнгэл нь архи дарс уух хийгээд амьтны мах идэх байлаа. Ингэж тэр өөрийн бүх амьдралаа өнгөрүүлсэн юм.”

Нэгэн удаа энэ тэнэг мулгуу Сушхарма нэгэн мэргэн хүний цэцэрлэгт ороод навч түүж байтал нэг хорт могой мөлхөн ирээд түүнийг хатгаж орхисноор тэрээр шууд л үхсэн байна. Үхсэнийхээ дараа тэрээр тамд унаж маш ихээр зовж шаналсны дараа шар үхрийн биеийг аван төржээ. Энэ шарыг нэгэн зэрэмдэг хүн худалдаж аваад ачлага уналгад хэрэглэдэг болов. Долоо, найман жил тэрээр хамгийн л хүнд хүчир ачааг нуруундаа тээн зөөжээ. Нэгэн удаа зэрэмдэг эзэн нь түүний нуруун дээр маш хүнд ачаа овоолж орхиод түүнийг туун явж байтал шар гэнэт ухаан алдан муужирч ойчжээ. Түүнийг тойрон олон тооны өрөвдөж энэрсэн хүмүүс цуглав. Нэг буянтай хүн түүнд өөрийн буянт үйлийн үр дүнгийн тодорхой хэсгийг өгөв. Үүнийг харсан тэнд байсан хүмүүс бүгд л өөр өөрсдийн сайн буялаг үйлийг эргэн санацгааж тэдгээрийнхээ тодорхой хэсгийг хөөрхий шард бэлэглэсэн байна. Энэ бужигнасан олон хүн дотор өөрөө өөрийгөө буянт үйл үйлдэж байсан эсэхийг ч үл мэдэх нэгэн биеэ үнэлэгч эмэгтэй байж л дээ. Тэрээр бусад хүмүүс өөрийн сайн үйлийн тодорхой хувийг шарт өгч буйг хараад тэр эмэгтэй хэзээ нэгэн цагт үйлдэж байсан байж болох буянт үйлийнхээ хэсгийг түүнд өргөн барьжээ. Ингээд шар ч үхэж, шууд л Ямаража буюу Үхлийн Тэнгэрийн орноо хүрч очив.

Ямаража түүнд хэлсэн нь: “Чи одоо биеэ үнэлэгч эмэгтэйн чамд өгсөн буянт үйлийн ачаар өөрийн үйлдэж байсан бүхий л нүгэлт үйлийн үр дагавраас ангижирлаа.” хэмээв.

Энэ бүх үйл явдлын дараагаар нэгэн буянт брахманы гэр бүлд мэндэлжээ. Энэ төрөлдөө тэрээр өөрийн урьдны амьдралаа буюу урьд насаа эргэн санах чадвар

бүхий нэгэн болж төрж гэнэ. Олон олон хоног өдрийн дараагаар тэрээр өнөөх өөрийг нь тамын амьдралаас салгасан биеэ үнэлэгч эмэгтэйг олж уулзахаар шийдэв. Тэгээд нөгөө эмэгтэйг ч олжээ. Танилцаж, мэнд усаа мэдэлцсэний дараагаар тэр: “Таны үйлдсэн ямар үйлийн үр дүн намайг тамын аймшигт байдлаас авран гаргаж чадваа” хэмээн асуув. Биеэ үнэлэгч эмэгтэй түүнд: “Эрхэм нөхөр минь, тэр торон дотор нэгэн тоть сууж буйг харж байна уу? Тэрээр өдөр бүр л ямар нэг зүйлийг давтдаг байлаа. Түүний уншлагыг сонссоор байгаад миний зүрх бүрнээ ариуссан юм. Энэхүү сонссон зүйлийнхээ үрийг чамд би дамжуулсан билээ” гэв. Ингээд үүний дараагаар тэр хоёр хоёул өнөөх тотид хандан юуг байнгад давтаад байдаг тухайг нь асуув. Тоть ч өөрийн урьдны амьдралаа эргэн санаж, түүх намтраа ярьж өгчээ. “Урьд нь би маш их эрдэм номтой нэгэн брахман байсан юм. Гэвч өөрийн чадварт эрдэн бардамнаж байнгад бусад ном эрдэмтэй хүмүүсийг доромжлон гутаадаг байв. Үхсэнийхээ дараагаар би маш олон янзын шийтгэл цээрлүүлэлтийг амссан бөгөөд удаан хугацаагаар зовж тарчилсны эцэст энэ тотины биеийг аван төрсөн билээ. Өөрийн урьд хийсэн нүгэлт үйлийн уршгаар миний эцэг, эх намайг жаахан байхад өнгөрсөн юм. Нэгэн удаа өмөг түшгээ алдсан би халуун элсэн дээр тарайн хэвтэж байхад минь намайг нэгэн риши/*даяанч*/ харж өөрийн ашрамд/*бясалгал хийх жижиг уру*/ авч ирж торонд хийсэн билээ. Тэр ришийн хүүхдүүд “Шримад Бхагавад гита”-гийн Нэгдгээр бүлгийг уншин цээжилж сурцгааж байв. Тэдний хэрхэн шлокийг давтан уншихыг сонссоор би мөн тэднийг даган давтан унших болов. Тун ч удалгүй намайг нэгэн хулгайч хулгайлан авч, энэ буянт эмэгтэйд худалдсан билээ” гэв.

“Бхагавад гита”-гийн Нэгдүгээр бүлгийг давтан уншсанаар тоть бүрэн дүүрэн ариуссан байна. Түүний давтан уншихыг сонссоор биеэ үнэлэгч эмэгтэй ч бүрэн төгс ариун болжээ. Харин энэ сонсолтын үр дүнгийн өчүүхэн хэсгийг хүртсэнээр Сушхарма мөн бүрэн төгс ариуссан билээ.

“Бхагавад гита”-гийн Нэгдгээр бүлгийн суу алдрын талаар бага зэрэг ярьж өгснөөр Сушхарма гэр лүүгээ буюу Бурхан зүг буцан одсон юм. “Шримад Бхагавад гита”-гийн Нэгдүгээр Бүлгийг даван унших хэн бүр маш хурднаар дээд төгс төгөлдөр Ваикунтхийн гаригуудад/*бурханлаг мөнхийн гаригс*/ хүрч очно. “Бхагавад гита”-гийн Нэгдгээр бүлгийг өөрт сонсогдохоор унших, эсвэл сонсох, эсвэл судлах ямар ч хүн материаллаг зовлон зүдгүүрийн далайг гатлан туулж Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд зүтгэх үйлчлэлийг олж авах бөлгөө.

Хоёрдугаар бүлгийн магтуу

Бурхан Вишну айлдсан нь: “Хайрт Лакшми минь ээ, Чи “Бхагавад гита”-гийн Нэгдүгээр Бүлгийн яруу алдрыг сонслоо. Одоо Миний өгүүлэх Хоёрдугаар бүлгийн гайхамшигийг анхааралтайгаар сонсогтун.

Нэгэн цагт өмнө зүгийн Пандхарпур хэмээх нэгэн хотод Девашайама нэрт их эрдэмт брахман амьдардаг байжээ. Тэрээр бүхий л төрлийн галан тахилгыг үйлдэх болон зочин гийчнийг хүлээж авахын чухлыг сайтар мэддэг нэгэн байв. Өөрийн үйл хэргээр тэр бүх сахиулсан тэнгэрийн тааллыг хангаж чадсан байлаа. Гэвч зүрх сэтгэл болон ухааны хувьд тэрээр аз жаргалтай, амар амгалан бус байсан тул сүнс болон Дээд сүнс, Параматма хоёрын хоорондын харьцааг ойлгон ухаарахыг ихэд чармайдаг байжээ. Үүний тулд тэрээр йогчид, тэвчил наминчлал үйлдэгчдийг урин

залж, тэдэнд үйлчлэн Туйлын Үнэний тухай асуун лавладаг байсан байна. Тийнхүү олон ч жилийг ардаа орхижээ.

Нэгэн удаа тэрээр зугаалж яваад, завилан сууж, харцаа хамрынхаа үзүүрт төвлөрүүлэн гүн бясалгалд автсан нэгэн йогчийг харж л дээ. Девашьяма, энэ йогч нь бүрнээ амар амгалан, материаллаг хүсэл сонирхол үгүй болсон хүн юм гэдгийг сайтар ойлгож байв. Гүн хүндэтгэлтэйгээр түүний өлмийд залбиран мөргөж ухаан санаагаа хэрхэн туйлын амар тайван байдалд хүргэж чадсан тухайг нь асуув. Дээд Бурханы Бодгаль, Бурхан Кришнагийн тухай мэдлэгийг бүрнээ эзэмшин чадсан тэрээр Девашьямаг Совпур нэрт тосгон руу явахыг зөвлөөд тэнд ямаа хариулагч Митраван нэрт хүнийг олж уулзан, түүнээс Бурханыг танин ухамсарлахуйн тухай эрдэм ухааныг олж авагтун хэмээн хариу өчив. Үүнийг сонссон Девашьяма дахин түүний өлмийд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөөд тэр даруй Совпурын зүгт яравчлан одов. Тэнд хүрээд тэрээр умард зүгт орших Митраваны амьдардаг хэмээн хэлсэн гайхамшигт ойг эрж олжээ. Ойд ормогц тэрээр нэг багахан голын эрэгт жижигхэн байц цохион дээр сууж буй Митраваныг олж харлаа.

Митраван бүрнээ амар амгалан, үнэхээр гайхамшигтай харагдаж байв. Ойд зөөлөн салхи үлээж, тал бүрээс тааламжит сайхан үнэр анхилж байлаа. Энд тэндгүй айдсын өчүүхэн ч сүүдэр үгүй ямаад бэлчиж байв. Тэрээр мөн ямаадын зарим нь бар болон бусад ойн догшин зэрлэг араатан амьтадтай зэрэгцэн хэвтэж буйг ч ажиглан харлаа.

Девашьяма ийм дүр зургийг хараад ухаан санаа нь туйлан амар амгалан болж, хүндэтгэлтэйгээр Митраванд дөхөн очиж дэргэд нь суув. Митраван бясалгалдаа бүрнээ автсан мэт санагдаж байлаа. Хэдэн мөчийн дараагаар Девашьяма түүнээс хэрхэн тэрээр Бурхан Кришнад үйлчлэн зүтгэх түвшинд хүрснийг нь шимтэн асуув. Асуултыг сонсоод Митраван хэсэгхэн зуур гүн бодлогошролд автсанаа хариу айлдсан нь: “Хүндэт, мэдлэг төгс Девашьяма минь ээ, дээр нэгэн цагт намайг ямаагаа хариулан явж байтал бидэн рүү ихэд улангассан нэгэн бар довтолсон юм. Амиа аврахын тулд ямаад маань бүгд л тал тал тийш таран зугадав. Түүнээс ихэд айн би ч мөн зугадлаа. Нилээд холдоод би миний ямаадын нэг нь голын эрэг дээр бартай яг халз тулсан байхыг харав. Гэтэл энэ үед нэн хачин жигтэй, гайхалтай үйл явдал боллоо. Барын уур омог гэнэт дарагдаж, ямааг маань идэх хүсэл нь үгүй унтран үгүй болсон байв. Ямаа маань түүнээс: “Чи хоолондоо хүрчихээд байж яагаад миний махыг идэхгүй байгаа билээ? Чи намайг бариад, бие махбодийг минь амтархан идэх ёстой биш үү? Гэтэл чи яагаад үл яарнав” хэмээн асууж байна.

“Эрхэм ямаа минь ээ, би яг энд ирмэгц л миний уур хилэн ор мөргүй алга болчихлоо. Үүний зэрэгцээ бас өлсөж, ундаасахаа ч байчихлаа” гэж нөгөө бар хариулж байна.

“Би ч мөн яагаад чамаас үл айж, өөрийгөө туйлын тайван амар байгаагийн учрыг нэг л олохгүй байна” гэж ямаа маань хариу өчлөө. Тэгээд, энэ чухам ямар учиртай юм бол? Хэрэв чи мэдэж байвал тэр тухай надад хэлж өгөөч гэв.

“Би ч мөн мэдэхгүй л байна гээд нөгөө бар, харин тэр хүнээс асууя хэмээн хэллээ.” Бар, ямаа хоёрыг хэрхэн өөрчлөгдөхийг хараад би ч мөн ихэд гайхлаа. Ингээд тэд над руу ойртон ирээд энэ бүхний учир шалтгааныг мэдэхсэн болов уу хэмээн надаас асуулаа. Энэ үед би ойролцоохь модон дээр суун буй нэгэн сармагчинг ажиглав. Бид бүгдээр хамтаар тэрхүү сармагчны хаанд дөхөн очоод би

түүнээс энэ тухай асуулаа. Сармагчин ихэд хүндэтгэлтэйгээр бидний асуултанд хариулав.

“Би та нарт нэгэн нэн эртний түүх ярьж өгье. Сонсоцгоогтун. Энэ ойд, та нарын яг өмнө Шива тэнгэр Шивалингаг залсан нэгэн том сүм байв. Эрт нэгэн цагт түүнд олон олон тэвчил наманчиллыг үйлдсэн Шукама хэмээх эрдэмт мэргэн амьдардаг байлаа. Тэрээр өдөр бүр голоос ус авч ирж, ойгоос цэцэг түүн Шива тэнгэрт мөргөдөг байжээ.

Чингэж тэрээр олон олон жилийг ардаа орхижээ. Нэгэн удаа түүн дээр нэгэн мэргэн хүн зочлон ирж л дээ. Шукама жимс, ус авч ирэн түүнийг ундалж дайллаа. Мэргэн хүнийг идэж, амарсных нь дараа Шукама: “Ай эрдэмт мэргэн минь ээ, би зөвхөн Бурхан Кришнагийн тухай эрдэм мэдлэгийг олж авахын тулд энд тэвчил наминчлал, үйлчлэл зүтгэлийг үйлдэн амьдардаг юм. Харин өнөөдөр тантай учирснаар би өөрийн үйлдсэн тэвчил, наминчлалын үр дүнг олж харлаа. Шукамын хүндэтгэл бишрэл дүүрэн үгийг сонсоод мэргэн ихэд баярлан урамшив. Тэрээр нэгэн чулууны хэлтэрхийн дээр “Шримад Бхагавад гита”-гийн Хоёрдугаар бүлгийг бичээд, түүнийгээ Шукамад өгч өдөр бүр түүнийг давтан уншиж байхыг захин сургаад: “Чингэснээр чи тун хурднаар өөрийн зорилгодоо хүрэх болно” хэмээв. Энэ үгийг хэлээд мэргэн гэв гэнэт алга болов. Ийнхүү мэргэний сургаал зөвлөгөөг баримтлан Шукама үхэн үхтлээ өдөр бүр энэ шүлгүүдийг сонсогдохуйц уншдаг байсан юм. Тун удалгүйгээр тэрээр Бурхан Кришнагийн тухай бүрэн дүүрэн мэдлэгийг хүлээн авсан хийгээд энэ шүлгүүдийг уншиж эхэлсэн өдрөөс хойш өлсөх ундаасах, шунал хомхойрлын хүсэл үгүй болжээ.

Энэ газарт үйлдсэн тэвчил наминчлал, үйлчлэл зүтгэлийн ачаар энд ирсэн ямар ч хүн өлсгөх ундаасах, шунал хомхойрлын хүсэл үгүй болох ба тэрхэн даруйд бүрэн дүүрэн амар амар амгаланд хүрдэг”.

Митраван хэлсэн нь: “Сармагчин энэхүү түүхийг ярьж дуусмагц бар, ямаа, бид гурав энэ сүмд хүрэлцэн ирсэн юм. Тэндээс бид чулууны хэлтэрхий дээр бичсэн “Шримад Бхагавад гита”-гийн Хоёрдугаар бүлгийг олов. Тэгээд би өдөр бүр тэрхүү шүлгүүдийг унших боллоо. Ингэж бид маш хурднаар Бурхан Кришнад үйлчлэн зүтгэх түвшинд хүрсэн билээ. Хүндэт брахман минь ээ, хэрэв чи “Шримад Бхагавад гита”-гийн Хоёрдугаар бүлгийг уншиж эхэлвэл тун хурднаар чи Бурхан Кришнагийн өршөөл ивгээлийг олж авна”.

Бурхан Вишну айлдсан нь: “Хайрт Лакшми минь ээ, тийнхүү Девашйама Митраванаас гайхамшигт эрдэм мэдлэгийг олж авсан юм. Тэрээр түүний өмнө сөгдөн мөргөөд буцан Пандхарпуртаа очоод өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Хоёрдугаар бүлгийг давтан унших болов. Ийнхүү тэрээр Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд хүрсэн юм.

Хайрт Лакшми минь ээ, үүнд “Шримад Бхагавад гита”-гийн Хоёрдугаар бүлгийн яруу алдар орших бөлгөө”.

Бурхан Вишну айлдсан нь: “Хайрт Лакшми минь ээ, Жанастхан нэрт хотод Каушикийн удмын Йада хэмээх нэгэн брахман амьдардаг байлаа. Энэ брахман нь брахман хүний хийх ёстой судар шастирт заасан шашин номын үйлийг хийж гүйцэтгэхээ больж, янз бүрийн буруу үйлийг үйлдэх болжээ. Тэрээр мөнгөөр

мөрий тавьж тоглох, архи дарс уух, ан хийх, биеэ үнэлэгч худалдан авах нэн дуртай нэгэн байв. Энэ бүхэнд тэрээр өөрийн хамаг эд хөрөнгөө үрж дуусгаад арилжаа наймаа эрхлэхээр умард зүгийг зорин оджээ. Тэнд тэрээр багагүй хөлжиж чинээлэгжээд Жанастхан хот руугаа буцах болж гэнэ. Аяны урт замыг туулж явсаар тэрээр нэгэн нэн их элсэн цөлд хоноглох болжээ. Нар шингэж эргэн тойрон үзэгдэх бараагүй харанхуй болсон тул модны нөмрт хоноглох болжээ. Шөнө дундын үест хэсэг дээрэмчид довтлон ирж түүнийг үхтэл балбаад хамаг л бараа таваарь, мөнгө хөрөнгийг нь тонон дээрэмдээд аваад явчихав. Йада нь шашин номын ямар ч үйлийг үйлдэхээ байж, нүгэлт амьдралын мөр хөөдөг байсан тул үхсэнийхээ дараагаар биегүй сүнс буюу буг чөтгөр болжээ.

Харин Йадагийн хүү нь маш их шүтлэгтэй, ведийн шастир номонд гаргуун нэгэн байв. Эцгийгээ удаан хугацаагаар Жанастхан хотноо буцан ирээгүйд сэтгэл зовнисон тэрээр түүнийг хайн олохоор эрэлд гарчээ. Газар сайгүй хэрэн явж, аяны урт замд таарсан аянчин болгоноос тэрээр эцгийгээ лавлан сураглаж явав. Нэгэн удаа тэрээр эцгийнх нь тухай мэдэх нэгэн хүнтэй таарсан бөгөөд тэр хүн түүнд эцэгт нь тохиолдсон бүгдийг ярьж өгсөн байна. Эцгийгээ үхсэн тухай сургийг дуулаад Йадын хүү түүнийг тамын амьдралаас авран суллах пинда(мөргөл) үйлдэхээр Каси(Бенарес) хотын зүг буцав. Буцах замд ес дэхь өдрөө тэрээр түүний эцэг дээрэмчдэд хорлогдсон мөнөөхь модны дор хоноглохоор болжээ. Орой нь тэрээр Кришна Бурханд мөргөдөг өдөр тутмын мөргөл залбирлаа үйлдээд мөн “Шримад Бхагавад гита”-гийн Гуравдугаар Бүлгийг чихэндээ сонсогдохуйц уншив. Уншлагаа дөнгөж дуустал тэнгэрээс нүргэлсэн чанга дуу гарав. Дээш хартал шар торгон өмсгөлтэй, дөрвөн мутартай гайхалтай үзэсгэлэн төгс дүрд хувилсан эцэг нь харагдав гэнэ. Түүний бие нь хар бараан борооны үүл мэт болоод тал бүр тийш нүд гялбам их гэрлийг цацруулж байв. Энэ үед эцэг нь түүнийг адислав. Хүү ч чухам юу болоод байгааг гайхан асуув. Эцэг нь : “Хайрт хүү минь ээ, чи “Шримад Бхагавад гита”-гийн Гуравдугаар бүлгийг дуудан уншсан тул намайг, миний урьдны үйлдэж асан нүгэлт үйлийн уршгаар олсон энэ буг чөтгөрийн биеэс ангижрууллаа. Одоо гэртээ харигтун. Учир нь чиний “Бхагавад гита”-гийн Гуравдугаар Бүлгийн уншсаны ачаар Каси хүрэх аяны зорилго тань хэдийнээ биелэгдсэн” гэв.

Хүү захиж хэлэх өөр сургаал захиас буйг асуухад эцэг нь хариулсан нь: “Ах маань мөн маш их нүгэлт амьдралын мөр хөөдөг байсан тул одоо тамын харанхуй мухарт зовж зүдэрч буй. Ийм учраас хэрэв чи түүнийг болон материаллаг орчлонгийн энд тэндгүй зовж зүдрэн байх бусад бидний өвөг дээдсийг ангижруулахыг хүсч байвал “Шримад Бхагавад гита”-гийн Гуравдугаар бүлгийг давтан уншигтун. Үүний ач тусаар тэд цөм Бурхан Вишну мэт хэлбэр төрхтэй биеийг хүлээн авах хийгээд Вайкунтхийн гаригт морилон хүрэх болно хэмээв.”

Эцгийн захиас сургаалыг сонсоод хүү хариулсан нь: “Хэрэв тийм бол би “Шримад Бхагавад гита”-гийн Гуравдугаар бүлгийг тамд зовж буй бүх сүнснүүдийг ангижран сулартал унших болно” гэв. Ийн хэлэхэд эцэг нь: “Ерөөлөөр тань болох болтугай” хэмээн адислав. Үүний дараагаар Вайкунтхийн буюу бурханы орны хөлөг онгоц гарч ирээд эцгийг нь бурханы орноо авч одлоо.

Ингээд хүү Жанастхан хотын зүгт буцан Бурхан Кришнагийн Шүтээний өмнө суун, тамын бүх болзолт сүнснүүдийг ангижруулан, чөлөөлөхийн тулд “Шримад Бхагавад гита”-гийн Гуравдугаар Бүлгийг давтан унших болов. Түүнийг ийн

уншиж байх мөчид Вишну Бурхан өөрийн элч нар буюу Вишнудутуудыг нүгэлт амьдралаар амьдрагч амьд оршнолуудыг шийтгэх ажлыг хариуцдаг Йамаражийн орноо илгээжээ. Йамаражийн орноо ирээд Вишнудутууд сүүн далай дээр Ананта-Шеша могой дээр залран байх Бурхан Вишнугийн илгээлтийг өвөрлөн яваа тухайгаа өгүүлэв. Тэд, Бурхан Вишну түүний амар мэндийг эрснийг уламжлаад тамд зовж буй бүх болзолт сүнснүүдийг тамаас суллан гаргахыг тушаасан болохыг дамжууллаа. Вишну Бурханы заавар тушаалыг сонсмогц Йамаража даруй бүх болзолт сүнснүүдийг суллан тавиад харин өөрөө Вишнудутуудтай хамт Бурхан Вишнуг харахаар Шветадвипа буюу сүүн далайн зүгт одов. Тэнд хүрээд тэрээр Ананта-Шеша суудал дээр залран ахуй Бурхан Вишнуг харлаа. Түүний бие махбодь нь олон олон нар мандсан мэт гэрэл сацруулан байв. Аз хийморийн охин тэнгэр Лакшми-Деви Түүний Өлмийг барилан сууна. Тал бүрээс нь Түүнийг аршууд, мэргэдүүд, Индра буюу Хурмаст тэнгэр тэргүүтэй сахиулсан тэнгэрүүд тойрон хүрээлж байв. Тэд бүгд л Бурхан Вишнуг магтан дуулж байлаа. Ведийг дуулан буй Брахма Тэнгэр ч тэнд мөн байв. Йамаража, Вишну Бурханд хүндэтгэлээ илэрхийлээд Түүнд хандан дараахь залбирлыг уншив: “Ай Эрхэм Хүндэт Вишну минь ээ, Та бээр бүхий л болзолт сүнснүүдэд сайн сайхныг хүсэгч хийгээд Танаас л Ведүүд үүсэн бий болсон билээ. Та бол цаг хугацаа бөгөөд цаг нь болоход бүгдийг устган сөнөөдөг билээ. Мөн Та бүх гурван ертөнцийг бүтээн бий болгох, тогтоон барихын учир шалтгаан билээ. Та зүрхэнд орших Дээд Сүнс хийгээд амьд амьтас бүрийн үйлийг хянан удирддаг билээ. Та бол орчлонгийн багш хийгээд бүх чин бишрэлтэнгүүдийн зорилго. Ай Бадамлянхуа нүдэт минь ээ, миний мөргөлийг дахин дахин хүлээн аваач. Таны яруу алдарт хэмжээ хязгаар үгүй билээ”.

Алгаа хавсран Йамаража бишрэл мөргөлөө Вишну Бурханд өргөв. “Таны тушаал заавраар тамын бүх болзолт сүнснүүдийг суллан тависан. Тиймд ямар ажил үүргийг надад тохоон өгөхийг хэлж болгооно уу”. Вишну Бурхан хариу айлдсан нь: “Эрхэм Дхармаража минь ээ, чи үнэхээр ийм л байх ёстой билээ. Үүрэг хариуцлагын талаар чамд сургах хэрэг юусан билээ. Өөрийн орноо буцагтун, Миний дүүрэн адислалыг хүлээн авч өөрийн үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэгтүн”. Тийн өгүүлээд Вишну Бурхан Йамаражийн нүдэнд үзэгдэхээ болив. Ингээд Йамараж өөрийн орноо буцан одов.

Энэ брахман амжилттайгаар тамаас өөрийн бүх өвөг дээдэс хийгээд бусад бүх болзолт сүнснүүдийг сулласны дараагаар Вишнудутууд хүрэлцэн ирж түүнийг Дээд Бурханы Бодгалийн бадамлянхуан өлмийд мөнхөд үйлчлэн зүтгэх Бурхан Вишнугийн орны зүгт авч одов.

Бурхан Вишну айлдсан нь: “Эрхэм хайрт Лакшми минь ээ, одоо Би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Дөрөвдүгээр Бүлгийн яруу алдрын тухай өгүүлье”.

Ганга мөрний эрэг дээр Каси(Бенарас) хотод Вишванатхийн сүмд Бхарата нэрт аугаа мэргэн амьдардаг байжээ. Тэрээр өдөр бүр маш их бишрэл сүсэгтэйгээр “Шримад Бхагавад гита”-гийн Дөрөвдүгээр Бүлгийг уншдаг байв. Эрт дээр нэгэн цагт тэрээр ариун мөргөлийн газар орноор аялан явахдаа Бурхан Кришнагийн Дүр Шүтээнийг харахаар Таподан хотод хүрчээ. Хотыг дайран гарч яваад тэрээр үр жимс нь сагсайсан хоёр байер модтой таарав. Сүүдэрт нь амарч тухлая гэж

шийдээд тэрээр нэг модны үндсийг дэрлэн, нөгөө модны үндэс дээр хөлөө тавин хэвтэв гэнэ.

Бхарата тэдгээр моддыг орхин явсны дараа хэсэг хугацаа өнгөрөхөд нөгөө модод хатан хувхайрч эхлэжээ. Тав, зургаа хоногийн дараагаар бүр хатан гандаж, эцэс сүүлд нь бүр үхэж гэнэ. Үүний дараагаар энэ хоёр модонд шингэн амьдарч байсан хоёр сүнс дараагийн төрөлдөө нэн их буянт брахманы охид болон төржээ. Нэгэн удаа долоон настай ахуйдаа тэд мөргөл үйлдэхээр Каси(Бенарас) хотын зүгт явж байв. Замдаа тэд мөнөөхь аугаа мэргэн Бхараттай учрах аз тохиожээ. Бхаратыг хармагц тэд түүний өлмийд мөргөн унаж, баяр талархлын үгээ хэлэв: “Ай Махаража Бхарата минь ээ, таны ачаар бид модны биед орших зовлонг ахуйгаас ангижирсан билээ”. Тэдний үгийг сонсоод Бхарата Махаража ихэд гайхав. Тэрээр асуусан нь: “Эрхэм хайрт охид минь ээ, бид хэзээ, хаана учирч, хэрхэн яаж та нарыг аварсан билээ. Чухам яагаад та нар мод болж төрөв? Энэ талаар би юу ч мэдэхгүй шүү дээ”. Үүний дараагаар охид, хэрхэн яагаад мод болон төрсөн тухай түүхээ Бхарата Махаражид ярьж өгчээ.

“Ай Махаража минь ээ, Годавари голын эрэг дээр Чиннапаап нэрт нэгэн ариун газар буй. Тэнд Сачапата нэрт арш амьдардаг байлаа. Тэр олон янзын хүнд бэрх тэвчил хатуужлыг үйлддэг байв. Халуун, дулааны улиралд тэрээр олон түүдэг галын дунд суудаг байсан хийгээд хүйтэн сэрүүн үед нь мөстэй усан дотор зогсдог байв. Цаг мөч өнгөрөхийн хирээр тэр мэргэн бүрэн төгс ариуссан хийгээд өөрийн мэдрэхүйнүүдээ бүрнээ эзэмшин чадаад Дээд Бурханы Бодгаль, Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд аажмаар хүрчээ. Өдөр бүр түүн дээр Брахма Тэнгэр хүрэлцэн ирж, түүнтэй уулзахын ялдамд, Бурхан Кришнад чин бишрэлээр үйлчлэхүйн тухай асуултуудыг тавидаг байв. Чингэвч Сачапацийн энэхүү өндөр байр суурийг хараад Индра Тэнгэр ихэд эмээн болгоомжлов. Учир нь нэгэн цагт тэрээр түүний тэнгэрийн хааны байр суурийг булаан авах вий хэмээн айжээ. Ингээд Индра Тэнгэр биднийг урисан билээ. Тэр үед бид тэнгэрийн хаант улсад апсар буюу тэнгэрийн бүжигчид байлаа. Тэгээд Индра бидэнд: “Сачапати миний байр суурийг булаан авахгүй байх боломжит бүхнийг хий, түүний оршин буй тэр газар тийш даруй явцгаагтун” хэмээн зарлиг буулгасан билээ”.

Индра Тэнгэрийн заавар тушаалыг аваад бид түүнээс салан шууд Сачапацийн тэвчил наминчлалаа үйлдэн буй Годавари голын эрэгт хүрэв. Тэнд бид дуулан, Сачапацийг ухаан санааг сарниулах, түүний бэлгийн дур хүслийг өдөөхийн тулд түүний тун ойрхонтой бүжиглэлээ. Бүжиглэж байх үест бидний хувцас хунар доош гулсан унаж цээжин биес маань нүцгэрэн ил гарсан билээ. Тэгмэгц мэргэн гартаа ус утган авч: “Эндээс үтэр зайлцгаа. Гангын эрэг дээр мод орших модод болцгоогтун” хэмээн хараасан юм. Түүний хараалыг сонсмогцоо бид түүний өлмийд сөхрөн унаж өршөөл авралыг хүсэн: “Эрхэм мэргэн минь ээ, биднийг өршөөн хайрлаж болгоогооч. Бид бол ердөө зараалаар яваа Индра тэнгэрийн үйлчлэгчид билээ” хэмээн өгүүлэхүйд бидний хүлцэнгүй байдлыг хараад мэргэний байдал зөөлөрч, биднийг Махаража Бхаратай учрах хүртэл мод хэвээр байх болно хэмээсэн билээ. Мөн тэрээр бидэнд өөрсдийн урьдны амьдралаа дурсан санаж байх адислалыг мөн хайрласан юм.

Эрхэм Махаража Бхарата минь ээ, Таподан зүг зочлон явах үедээ бидний оршин байсан модны дор амран ахуйдаа та “Шримад Бхагавад гита”-гийн Дөрөвдүгээр Бүлгийг уншсан билээ. Энэхүү уншлагыг тань сонсоод бид мод хэмээх бие махондид

оршин байх ахуйгаас ангижран чөлөөлөгдсөн төдийгүй Бурханы чин бишрэлтний гэр бүлд төрсөн. Түүнчлэн бид материаллаг ертөнцөд цэнгэн жаргах бүхий л дур сонирхлоосоо эгнэгт ангижирсан юм”.

Бурхан Вишну айлдсан нь: “Хайрт Лакшми минь ээ, Охид энэ түүхийг Махаража Бхаратад ярьж өгөхөд тэрээр маш ихэд сэтгэл ханан баясаад өөрийн ашрамын зүгт явж одов. Харин тэр хоёр охин хоёул бүхий л амьдралынхаа туршид “Шримад Бхагавад гита”-гийн Дөрөвдүгээр Бүлгийг уншин байсан хийгээд Миний бадамлянхуан өлмийд үйлчлэн зүтгэх өмөг түшгийг олсон билээ”.

5

Бурхан Вишну айлдсан нь: “Одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Тавдугаар Бүлгийн суу алдрын талаар ярьж өгье. Анхааралтайгаар сонсогтун”.

Мадра улсад Пуру Кутсапур хэмээх хот бий бөлгөө. Тэнд Пингала хэмээх нэрт нэгэн брахман амьдардаг байв. Хүүхэд ахуйд нь түүнийг Ведийн эрдэм ухаан, элдэв төрлийн брахманы үйл хэрэгт сургажээ. Гэвч энэ бүгд түүний сонирхлыг огт татсангүй. Өсч эрийн цээнд хүрээд тэрээр брахманы үйлээ орхиж харин дуулж, бүжиглэж, хөгжмийн зэмсэг дээр тоглож сурчээ. Аажмаар тэрээр энэ урлагт гаргуун нэгэн болж бүр тэр улсын хаан өөрөө түүнийг ордондоо амьдрахыг урьж гэнэ. Ордонд тэрээр нүгэлт амьдралын гүн рүү улам улмаар живжээ. Хааны нэн ойрын шадар хүрээлэлд багтсан тэрээр их л бардам зантай болов. Ялангуяа түүнд хаантай хоёулхнаа байж түүнд хов зөөж, алтан хошуу өргөх нь юу юунаас таалагддаг байв. Пингалын эхнэр Аруна доод гарлын гэр бүлд төрсөн нэгэн байлаа. Тэрээр шунал тачаал маш ихтэй байсан хийгээд олон ч эртэй цэнгэл эдлэж байжээ. Энэ тухайг нь нөхөр нь мэдсэн тул тэрээр нөхрөө хорлохоор шийдэв гэнэ. Нэгэн удаа шөнө дөл болсон хойно тэрээр нөхрийнхөө толгойг унтаж байхад тасдан хаяад биеийг нь цэцэрлэгт булж орхив. Үхсэнийхээ дараагаар Пингала тамын хамгийн гүнд унаж удаан хугацаагаар зовж тарчилсны дараа дэлт бүргэд шувуу болон төржээ. Аруна эрх дураараа эрчүүдтэй цэнгэл эдлэж байсаар айхтар хөнөөлтэй арьс өнгөний өвчнөөр өвдөж тун ч удалгүй түүний бие үзэшгүй муухай, ой гутам болж гэнэ. Ингэсээр тэрээр удалгүй үхэж мөн л там руу одов. Удаан хугацаанд тэнд зовлон эдэлсний дараагаар нэгэн эм тотины биеийг авч төрөв.

Нэгэн удаа тэрээр идэш хоол хайн явж байтал түүнийг, урьд нь Пингала байсан нөгөөх дэлт бүргэд харчихаж гэнэ. Өөрийн урьдны амьдралаа эргэн санаад, энэ тоть нь түүний эхнэр байсан гэдгийг мэдмэгц түүнийг тэр даруй хурц хошуугаараа тоншин егүүтгэв. Тоть доош унахдаа усаар дүүрсэн хүний гавлын ясан дээр унаад, түүнд живж гэнэ. Гэнэт нэгэн анчин гарч ирээд дэлт бүргэдийг харваж алав. Дэлт бүргэд ч мөн газар унаж толгой нь мөнөөх гавлын ясан дээр цохигдон дотор нь байсан усыг залгиж орхиод үхжээ.

Ингээд дараа нь Йамаражийн элч нар хүрч ирээд тэднийг үхлийн орны зүгт авч одов. Энэ мөчид тэд өөрсдийн урьдны нүгэлт амьдралыг бодон маш ихээр айн түгшиж байлаа.

Тэднийг Йамаражийн өмнө авч ирэхэд тэрээр хэлсэн нь: “Та нар одоо өөрсдийн нүгэл хилэнцээс ангижирсан бөгөөд Вайкунтхийн гаригс тийш одож болно”. Пингала, Аруна хоёр үүнийг сонсоод ихэд гайхан ямар учраас ийм нүгэлт хоёр сүнс Вайкунтхийн гаригт хүрэх эрхийг олж авсныг асуув.

Йамаража хариулсан нь: “Ганга мөрний эрэг дээр Ват нэрт Бурхан Вишнугийн аугаа их чин бишрэлтэн амьдарч байв. Тэрээр шунал тачаал хийгээд сувдаг хомхой сэтгэлээс ангид нэгэн байлаа. Тэрээр өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Тавдугаар Бүлгийг уншдаг байсан юм. Тийн нас нөгчөөд тэрээр шууд л Вайкунтхийн гариг тийш зорин одсон билээ. Өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Тавдугаар Бүлгийг давтан уншдаг байсны ачаар түүний бие махбодь туйлын цэвэр ариун болсон ба энэ чин бишрэлтний гавлын ясанд шүргэн хүрэлцсэнээр та хоёр ч Вайкунтхид хүрэх боломжийг оллоо. Үүнд “Бхагавад гита”-гийн Тавдугаар Бүлгийн яруу алдар орших бөлгөө.

Бурхан Вишну айлдсан нь: “Хайрт Лакшми минь ээ, Йамаражаас “Бхагавад гита”-гийн гайхам алдрыг сонсоод тэд маш их аз жаргалыг мэдэрч тэднийг Вайкунтхийн зүгт авч одох цэцгэн хөлөг онгоцонд суув.

“Бхагавад гита”-гийн Тавдугаар Бүлгийг сонссон ямар ч хүн тэр ч атугай тэрээр хамгийн их нүгэлтэн байлаа ч Вайкунтхийн гаригт гарцаагүй хүрэх болно”.

6

Бурхан Вишну айлдсан нь: “Одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Зургаадугаар Бүлгийн яруу алдрын талаар ярьж өгье. Энэ хүүрнэлийг сонссон хэн бүр материаллаг ертөнцөөс ангижрах болно”.

Годавари мөрний эрэг дээр Пратхитханпур(Пайатхан) нэрт хот бий билээ. Тэр хотынхон Намайг Пиппалеш нэрээр сайн мэдэх бөлгөө. Энэ хотод хэмжээгүй их өгөөмөр зангаараа олонд хайрлагдсан Жаншрути нэрт хаан амьдардаг байв. Өдөр бүр тэрээр их галан тахилга үйлддэг байсан хийгээд түүнээс гарсан утаа униар нь тэнгэрийн орны цэнгэл жаргалын цэцэрлэг Нандаванд хүрч тэнд ургадаг хүслийг биелүүлэгч калпаврикша моддын цэцэг, навчисыг хар өнгөтэй болгодог байсан тийм баялаг, өргөн дэлгэр тахилга өргөл байлаа. Өөрсдийн буй төрхөөрөө тэдгээр модод өөрсдийн хүндэтгэлийг Жаншрути хаанд илэрхийлж байгаа мэт байдаг байв. Энэ аугаа хааны буянт үйлсийн ачаар сахиулсан тэнгэрүүд хүртэл Пратхитханпур хотод буун ирдэг байв. Жаншрути хаан буян үйлдэж өглөг тараахдаа яг л хурын үүлс бороо асган цутгаж байгаа мэт байдаг тийм л өглөгч хаан байв. Түүний цэвэр шашин номын үйлийн ачаар бороо хур үргэлж цаг хугацаандоо ордог хийгээд газар дэлхий ургац, тариагаар элбэг баян, тэнд зургаан янзын оготно хулганы үнэр ч үгүй байдаг байлаа. Тэрээр өөрийн харъяат албатуудын төлөө байнгад худаг гаргаж, нуур цөөрөм байгуулдаг байжээ. Түүнд ихэд сэтгэл ханасан сахиулсан тэнгэрүүд хун шувууны дүрд хувилан ордонд залран бууж түүнд адислал ерөөлөө хайрлав. Өөр хоорондоо ярилцан тэд нэг нэгнийхээ араас тэнгэрт хөөрөн нисэв. Бхадрашава хоёр, гурван хунгийн хамт бүх хунгийн сүргийн тэргүүнд нисэн явж байлаа. Гэтэл бусад нь түүнд хандан: “Ах минь ээ, та яагаад хажуугаар нисэн өнгөрнө вэ? Та өөрийн хүсэл зорилгоор бүх дайснаа даран сөнөөх чадалтай аугаа их хаан Жаншрутиг харахгүй байна гэж үү?” гэсэн хунгуудын үгийг сонсоод Бхадрашава инээмсэглэн: “Ай ах дүү нар минь ээ, Энэ Жаншрути хаан аугаа мэргэн Раиква шиг аугаа гэж үү” хэмээв.

Хунгийн үгийг сонсоод хаан тэрхэн дороо өөрийн өндөр ордны дээврээс буун баясгалантайгаар хаан ширээндээ залрав. Тэрээр өөрийн хөтчөө дуудан аугаа

мэргэн Раикваг даруй түргэн олохыг даалгав. Хааныхаа тушаалыг сонсоод Маха нэрт хөтөч ихэд сэтгэл ханаад Раиква мэргэнийг хайн олох эрэлд гарав.

Эхлээд тэрээр бүгдийн сайн сайхны төлөө амьдран байдаг Вишванатхын Кашипур хотыг дайрч өнгөрлөө. Дараа нь тэрээр хүн бүрийг үхэх, төрөхийн гав гинжнээс салгаж чадах бадамлянхуа мэлмийт Гададхара Бурханы оршин байдаг Гайагаар дайран гарав. Олон олон ариун мөргөлийн газар орноор дайран өнгөрч тэрээр бүхий л нүгэл хилэнцийг устган зайлуулах Матхур хотноо хүрэлцэн ирэв. Тэнд Дээд Бурханы Бодгаль Бурхан Кришна Өөрөө амьдран байлаа. Бүх аугаа мэргэд, сахиулсан тэнгэрүүд, түүнчлэн Ведүүд болон бусад шастирууд биелсэн хэлбэр төрхөөрөө тэвчил наминчлалыг үйлдэн Бурхан Кришнад үйллэн зүтгэж байв. Матхур нь хагас сар хэлбэртэй бөгөөд чин бишрэл сүсгийг хайрлах гайхамшигт мөрөн Йамуны эрэгт орших ажээ. Тэнд хаан титмэнд шигтгэсэн аварга том үнэт эрдэнийн чулуу мэт, Матхур-Мандалын алдар сууг өсгөн мандуулах гайхамшигт уул Говардхан оршин байна. Тэр уул ариун сайхан модод хийгээд рептилүүдээр хүрээлэгдсэн байх ба Матхурыг тойрон Кришна Өөрийн гайхалтай тоглоом наадмаар цэнгэн наадан байсан арван хоёр үзэсгэлэнт ой оршин байв.

Матхурыг дайран өнгөрөөд Маха өрнө зүгт довтолгов. Дараа нь умард зүгт бэдрэв. Нэгэн удаа тэрээр Кашмир хотод хүрээд тэнд нэгэн аварга том гэрэл сацарсан цагаан орд харшийг олж харав. Энэ хотод орших хүн бүр тэр ч атугай хамгийн мулгуу тэнэг нь хүртэл сахиулсан тэнгэр мэт үзэсгэлэн төгс харагдаж байв. Энэ нь тэнд байнгад галан тахилга өргөлийн гал дөл бадран байдгийн ач тус ажээ. Хотын дээгүүр бүхэл бүтэн үүлэн хөшиг татсан мэт харагдах авай. Энэ хотод Шива Тэнгэрийн Шүтээн болох Маникешвар залран байдаг ажээ. Кашмирын хаан өөрийн олон дайсныг сөхрүүлэн дараад дайнаас дөнгөж ирээд байсан ба Шива Тэнгэрт мөргөн байв. Шива Тэнгэрт үлэмж чин сүсэг бишрэлтэй тул хаан Маникешвар нэрээр ихэд алдаршсан байлаа. Сүмийн яг үүдэн дээр Маха, модны дор суух, жаахан ачаа үүрсэн аугаа мэргэн Раикваг олж харав. Тэрээр Жаншрутийн тодорхойлон өгүүлснээр Раиква мэргэнийг танисан хийгээд тэр даруй түүний өлмийд сөхрөн асуусан нь: “Ай аугаа мэргэн минь ээ, та чухам хаана амьдардагсан билээ? Таны алдар нэр хэн бэ? Та харваас аугаа их бодгаль ажээ! Чухам юуны учир энд сууна вэ?”. Махагийн үгийг сонсоод Раиква жаахан бодлогошрон байснаа хариулсан нь: “Би бүхэнд сэтгэл хангалуун байдаг. Надад юу ч хэрэггүй” гэв.

Маха энэ хариултыг сонсоод бүгдийг өөрийн зүрх сэтгэлээр ойлгов. Тэрээр Пратиштханпур хотын зүгт буцан урт аян замдаа яаран гарав. Буцан ирээд тэрээр шууд хаандаа мэхийн ёслож хүндэтгэл илэрхийлээд алга хавсран болсон бүх зүйлийн талаар ярилаа. Энэ тухай сонсоод хаан тэр даруй аугаа мэргэн Раикватай уулзахаар шийдэж гэнэ. Үнэ цэнтэй олон янзын бэлэг сэлтийг бэлдэж, үлэмж тансаг сүйх тэргэнд суун Кашмирын зүт хөдлөв. Тэнд хүрэлцэн очоод мэргэнд дөхөн очиж түүний өлмийд сөгдөн мөргөөд өмнө нь авч ирсэн үнэт эрдэнэ, торго дурднаа дэлгэн барив. Хааны энэ байдалд ихэд уурссан Раиква мэргэн хэлсэн нь: “Өө тэнэг мулгуу хаан минь ээ, энэ хэрэгцээгүй хог новшнуудаа авч тэргэндээ ачаад эндээс даруй түргэн явтугай” хэмээв. Хаан гүн их чин бишрэлтэйгээр Раиквын өлмийд сөхрөн унаж өршөөл эрэн, түүнд өршөөл нигүүлсэлтэй хандахыг гуйн болгоов. Тэрээр Раиква мэргэнээс: “Ай мэргэн минь ээ, та чухам хэрхэн яаж Бурханд үйлчлэх чин бишрэл сүсэг, огоорлын энэ дээд төлөвт хүрч чадаа вэ?” хэмээн асуув.

Хааны хүлцэнгүй төлөв байдалд зөөлөрсөн Раиква хариу өчсөн нь: “Би өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Зургаадугаар Бүлгийг сонсогдохуйц уншдаг билээ” гэв.

Жаншрути, Раиква мэргэнээс “Шримад Бхагавад гита”-гийн Зургаадугаар Бүлгийг сонссоны дараагаар тэрээр мөн өдөр бүр энэхүү Зургаадугаар Бүлгийг унших болов. Цаг нь болоход цэцгэн хөлөг онгоц гарч ирэн түүнийг Вайкунтхийн зүгт авч одов. “Шримад Бхагавад гита”-гийн Зургаадугаар Бүлгийг өдөр бүр уншдаг мөнөөхь аугаа мэргэн ч Дээд Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд үйлчлэн зүтгэхээр Вайкунтхийн зүгт одож гэнэ.

“Шримад Бхагавад гита”-гийн Зургаадугаар Бүлгийг давтан унших хэн бүр машид хурднаар Дээд Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд үйлчлэх түвшинд хүрэх бөлгөө. Үүнд эргэлзэх зүйл огтхон ч үгүй билээ.

7

Шива Тэнгэр хэлсэн нь: “Эрхэм хайрт Парвати минь ээ, одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Долоодугаар Бүлгийн яруу алдрын тухай ярьж өгье. Үүнийг сонссон хүний чих бурханлаг рашаанаар дүүрэн бялхмуй”. Паталипутра хэмээх олон олон хаалгатай асар том хот орших бөгөөд энэ хотод Шанкуркарна хэмээх нэрт нэгэн брахман амьдран суудаг байв. Тэрээр үйлдвэрлэл эрхлэн ихээхэн хөрөнгө зорь хуримтлуулжээ. Харин тэрээр хэзээ ч чин бишрэлийн алба үйлэнд зүтгэж байгаагүй хийгээд мөн өөрийн өвөг дээдсийн төлөө элдэв янзын зан үйлийн алиныг ч үйлдэж байгаагүй гэнэ. Тэрээр нэн баян бөгөөд аугаа их хаадууд ч түүний орон гэрт зочлон хооллож байв. Хэдий тийм ч Шанкуркарна маш их харамч учраас өөрийн хураасан эд хогшлыг газарт нүх малтан ухаж далдын далд хадгалдаг байжээ.

Нэгэн удаа энэ брахман өөрийн үр хүүхэд, төрөл төрөгсөдтэйгээ дөрөв дэхь удаагаа гэр бүл болох ёслол үйлдэхээр аялан явж байгаад нэгэн газарт хоноглох болжээ. Шөнө дунд унтаж байх үест нэгэн могой мөлхөн ирээд түүнийг хорт хэлээрээ хатгаж орхив. Эцэгт нь юу тохиолдсоныг харсан хүүхдүүд, төрөл төрөгсөд нь эмч домч, мөн мантра уншин эмчлэгч зэрэг хүмүүсийг дуудан авч иржээ. Гэвч тэдний аль нь ч Шанкуркарнад туслаж чадсангүй төд удалгүй үхэж гэнэ. Үхсэнийхээ дараагаар тэрээр претха-шарпа буюу могой-хий үзэгдэл болон хувирав. Өөрийн хурааж хуримтлуулсан эд хөрөнгөө тэрээр гэрийнхээ ойролцоо газарт ухан булсан байсан нь түүний бодол санаанд эргэлдэх ганц зүйл байлаа. Эд хөрөнгөө хаана нууснаа тэрээр өөрийн гэр бүлийнхэндээ ч хэлээгүй байжээ. Түүнийгээ бусдад алдахгүйн тулд тэрээр могой-хий үзэгдлийн биед оршин байсан ч эд хөрөнгө хадгалсан тэр газартаа орших болов. Хэсэг хугацааны дараа претха-шарпа буюу могой-хий үзэгдлийн биед оршин байж залхсан тэрээр өөрийн хүүхдүүдийн зүүдэнд нэвтрэн орж өөртөө туслахыг хичээнгүйлэн гуйв. Өглөө сэрээд залхуу хүүхдүүд нь нэг нэгэндээ урьд шөнийн зүүдэлсэн зүүдүүдээ ярьж өгцгөөжээ. Тэдний нэг нь том хүрз шүүрч аван эцгийнхээ зааж өгсөн газар тийш чиглэн алхав. Тэнд хүрээд тэрээр чухам мөнөөхь дармал эд баялаг хаана буйг мэдэхгүйгээ ойлгов. Хүүхдүүдийн дотроос хамгийн шунахай хомхой тэр хүү удаан хугацаагаар эрдэнэсийг эрж хайсан бөгөөд эцэст нь нэгэн могойн нүхэнд хүрээд түүнийг яаран ухан сэндийчиж эхлэв.

Тун ч удалгүй тэр нүхнээс нэгэн аймшигт дүр төрхтэй аварга том могой гарч ирээд: “Ай тэнэг мулгуу амьтан минь ээ, чи хэн гээч вэ?” Чи яах гэж наашаа ирээ вэ? Чамайг хэн нааш нь явуулав? Яах гэж чухам энд газар ухаад байгаа билээ? Миний асуултанд түргэн хариул!” хэмээн зандчив.

“Би таны хүү тань билээ. Миний нэрийг Шива гэдэг. Урьд шөнө би энд нууцлагдмал эрдэнэ хадгалсан болохыг зүүдэндээ харсан билээ. Тэгээд түүнийг авахаар ирлээ” хэмээн хүү хариулав. Шивагийн хэлэхийг сонссон претха-шарп инээмсэглэн хэлсэн нь: “Хэрэв чи миний хүү мөн л юм бол яагаад чухам намайг энэхүү тамын зовлонг байдлаас гаргах зайлшгүй үйлдвэл зохих зан үйлүүдийг үл хийнэ вэ? Би өөрийн хомхой сувдаг зангийн улмаас энэ биеийг авсан билээ. Харин одоо чи мөн л тэр замаар замнаж байна”.

Хүү асуусан нь: “Хайрт эцэг минь, хэрхэн яаж таныг энэ нөхцөл байдлаас салгах билээ? Энэ тухай хэлж өгнө үү” гэхэд претха-шарп хариулсан нь: “Ямар ч төрлийн буян болон тэвчил наминчлал, өргөл тахилга хэрэггүй. Харин “Шримад Бхагавад гита”-гийн Долоодугаар Бүлгийг давтан уншсаны ачаар би үхэх төрөхийн тойргоос лавтай туулан гарч чадах билээ. Хайрт хүү минь, шраддха зан үйлийг/өнгөрөгсдийн хойноос үйлдэх зан үйл орч./ даруй хийгтүн. Үүний тулд “Шримад Бхагавад гита”-гийн Долоодугаар Бүлгийг унших брахман хүнийг уриж, маш элбэг тансагаар түүнийг хооллож ундал”.

Энэ бүхний дараагаар Шива ах нарын хамт эцгийнхээ захиас сургаалыг биелүүлсэн ба урин залсан брахманыг “Шримад Бхагавад гита”-гийн Долоодугаар Бүлгийг уншин дуултал Шанкуркарна претха-шарпын аймшигт бие махбодийг орхин дөрвөн мутарт бурханлаг биед хувирав. Ингээд тэрээр хүүхдүүдээ адислан ерөөж, эрдэнэс нуусан газраа зааж өгөөд Вайкунтхийн гаригс тийш залран одов.

Үр хүүхдүүд нь Бурхан Кришнад үйлчлэн зүтгэхүйн үйлэнд ухаан санаагаа төвлөрүүлж, мөнөөх эд баялагаар гайхамшигт сүм хийд бариулж, худаг, цөөрөм гаргуулж, хоол хүнсийг өглөг болгон тараажээ. Тэд бүгдээр өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Долоодугаар Бүлгийг давтан уншдаг байсан хийгээд тун ч хурднаар Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд хүрчээ.

Шива Тэнгэр хэлсэн нь: “Хайрт Парвати минь ээ, ийнхүү би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Долоодугаар Бүлгийн гайхамшигт алдрыг өгүүллээ. Энэ түүхийг сонссон ямар ч хүн бүхий л төрлийн нүгэлт үйлийн уршгаас даруй ангижирмуй”.

Шива Тэнгэр айлдсан нь: “Хайрт Парвати минь ээ, одоо чи “Шримад Бхагавад гита”-гийн Наймдугаар Бүлгийн яруу алдрыг сонсогтун. Түүнийг сонсож мэдсэнээр чи нэн их баяр хөөрт дүүрэн автмуй”.

Өмнө зүгт Амардх-Капур хэмээх хотод нэгэн биеэ үнэлэгч эмэгтэйтэй гэрлэсэн Бхавашарма нэрт брахман амьдардаг байжээ. Тэрээр мах идэж, архи дарс ууж, хулгай хийж, бусдын эхнэртэй нөхцөж, ан хийх зэргээр зугаацан цэнгэдэг байв. Нэгэн удаа нүгэлт Бхавашарма оройн зоогонд уригдаж гэнэ. Тэнд тэрээр архи дарсыг ханатлаа ууж сүүлдээ нөгөөх нь шингэхээ байж эргүүлэн гаргаж байв. Оройн цэнгүүний дараа тэрээр ихээр огиулан бөөлжиж, маш хүнд цусан суулга

өвчнөөр өвдөж олон хоногоор зовж шаналсны эцэст нас нөгчин нэгэн хасарваань мод болон төржээ.

Нэгэн удаа хоёр брахман-ракшас(брахман хүний, бие олоогүй сүнс) энэ хасарваань модны доор хоргодох болов. Тэдний урьдны амьдралын түүх ийм бөлгөө.

Кушибал нэрт брахман нь ведийн мэдлэгт ихэд нэвтэрхий хийгээд бусад бүх төрлийн салбар мэдлэгт гаргууд нэгэн байв. Түүний эхнэрийг Кумати гэдэг байсан ба тэрээр зан ааш их муутай ажээ. Хэдий боловсрол мэдлэг сайтай ч тэр брахман үлэмж их сувдаг хомхой нэгэн байлаа. Тэрээр өдөр бүр эхнэрийн хамт олон өглөг буяны зүйлийг хүлээн ававч хэзээ ч түүнийгээ бусадтай хуваалцаж байсангүй. Ингээд нас нөгчих цаг болоход тэд брахма-ракшас болж гэнэ. Энэ биед оршоод тэд өлсөж, цанган зүдэрч байнгад газар дэлхийгээр хэрэн хэсүүчлэн явах болов. Нэгэн удаа тэд мөнөөх хасарваань модны дор амарч байх зуурт эхнэр нь нөхрөөсөө: “Бид чухам хэрхэн яаж брахма-ракшас байх хараалаас мултран гарч болох вэ?” хэмээн асуув. Нөхөр нь хариулсан нь: “Брахманы тухай мэдлэг, сүнсний тухай мэдлэг, үйлийн үрийн тухай мэдлэггүйгээр бид өөрсдийн нүгэлт үйлийн үр дагавраас ангижирах боломжгүй билээ”. Үүнийг сонссон эхнэр нь: “Ай Эзэн минь ээ, Брахман гэж юу юм бэ? Сүнс гэж юу юм ? Үйлийн үр гэж юу юм бэ?”(ким тад брахма ким тад адйатам ким карма пурушоттама) хэмээн асуув. Үнэхээрийн санамсаргүйгээр түүний эхнэр “Шримад Бхагавад гита”-гийн Наймдугаар Бүлгийн нэг дэхь шүлгийн хагасыг хэлж орхив. Энэхүү хагас шүлгийг сонсмогц Бхавашарма тэрхэн даруй мөнөөх модноос сугаран гарч нүгэл хилэнцээс бүрнээ ангид брахманыхаа бие махбодийг хүлээн авав.

Тэнгэрт гэнэт цэцгэн хөлөг онгоц гарч ирээд эхнэр, нөхөр хоёрыг хамтад нь буцаагаад гэр орон руу нь, Бурхан зүгт буюу Вайкунтхийн гариг тийш авч одлоо.

Энэ бүхний дараагаар Бхавашарма нэн гүн хүндэтгэлтэйгээр энэхүү хагас шүлгийг (*ким тад брахма ким тад адйатам ким карма пурушоттама*) бичин үлдээсэн хийгээд Бурхан Кришнад үйлчлэхээр шийдэн Кашипурийн зүгт одож тэнд байнгад энэ хагас шүлгийг давтан уншиж, тэвчил наминчлалыг ихээр үйлдэх болжээ.

Тэр үед Вайкунтхийн гариг дээр Лакшми, түүний нөхөр гэнэт амарч хэвтэхээ болин тух алдахыг хараад алга хавсран асуусан нь: “Чухам яагаад Таны унтах нойр тань хулжин одов ?” хэмээхүйд Бурхан Вишну айлдсан нь: “Хайрт Лакшми минь, Ганга мөрний эрэг дээр Кашипур хотноо Миний нэгэн чин бишрэлтэн “Шримад Бхагавад гита”-гийн Наймдугаар Бүлгийн хагас шүлгийг тасралтгүй давтан уншиж аугаа их тэвчил наминчлалыг үйлдэн байна. Түүний үйлчлэл зүтгэлийг хэрхэн шагнаж урамшуулахаа удаан хугацаагаар Би бодож цөхөв” гэв.

Парвати, Шива Тэнгэрээс асуусан нь: “Вишну Бурхан Өөрийн чин бишрэлтэнд сэтгэл ханамжтай байснаар чухам ямар адислалыг түүнд хайрладаг юм бол ?” гэхэд Шива Тэнгэр хариулсан нь: “Бхавашарма Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд мөнхөд үйлчлэн зүтгэхээр Вайкунтхийн зүгт одсон билээ. Зөвхөн тэр өөрөө төдийгүй мөн түүний бүхий л өвөг дээдэс Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд хүрсэн юм. Хайрт Парвати минь, би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Наймдугаар Бүлгийн яруу алдрын өчүүхэн бага хэсгийг л ярьж өглөө”.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Хайрт Парвати минь ээ, одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийн гайхам алдрын талаар ярьж өгье”.

Нармада голын эрэг дээр Махишмати нэрт хот орших бөгөөд тэр хотод Мадхава хэмээх нэгэн брахман амьдрах бөлгөө. Тэрээр Ведийн сургаал зарчмыг хатуу баримталж, брахман хүнд байвал зохих бүх сайн чанарыг шингээсэн байсан бөгөөд өөрийн эрдэм мэдлэгийн ачаар багагүй бэлэг сэлтийг хүлээн авдаг байв. Хурааж хуримтлуулсан тэр эд баялагаараа аугаа том тахилга өргөлийг үйлддэг байсан хийгээд тахилга хийхэд зориулан нэгэн ямааг худалдан авч гэнэ. Тахилга үйлдэхийн өмнөхөн түүнийг ариусгах үйлийг хийх болтол мөнөөх ямаа гэнэт тачигнатал инээж, чангаар: “Өө брахман, биднийг зөвхөн үхэх, төрөхийн тойрогт уян барих тоогүй олон галан тахилга үйлдэхийн учир юусан билээ? Энэ галан тахилгыг үйлдсэнээр надад юу тохиолдохыг хар” хэмээн өгүүлж тэнд байгсадыг алмайруулав.

Ямааны энэ үгийг сонсоод хурсан олон ихэд гайхан сонирхов. Харин брахман маш хүндлэлтэйгээр алгаа хавсран асуусан нь: “Чи хэрхэн яагаад ямаа болоо вэ? Урьд насандаа чи ямар анги давхаргад харъяалагддаг, ямар үйлийг эрхэлдэг байв?” гэхэд ямаа хариулсан нь: “Ай брахман минь, урьд насандаа би цэвэр ариун брахманы гэр бүлд төрсөн хийгээд Ведэд заагдсан бүх зан үйлийг ихэд хичээнгүйлэн үйлддэг байлаа. Нэгэн удаа хүүхэд маань өвдөөд түүний өвчнийг илааршуулахын тулд эхнэр маань Дурга охин тэнгэрт мөргөл хийхээр шийдэв. Энэ тахилгыг үйлдэхийн тулд тэрээр надад тахилгад хэрэглэх ямаа олохыг даалгалаа. Тэр үед бид нэгэн ямааг олж хөглөөд Дурга Эхийн сүмд өргөл болгохоор авч очтол тэрээр гэнэт намайг: “Ай нүгэлт үйлт, алив болгоны адаг болсон амьтан минь ээ, чи миний үр хүүхдүүдийг эцэггүй өнчрүүлэн үлдээлээ. Энэ нүглийнхээ төлөө чи өөрөө ямаа болох болно доо” хэмээн хараав. Ай Мадхава, ингээд миний үхэх цаг болоход би ямааны биеийг авсан ч Бурхан Говиндын ачаар өөрийн урьд насаа мартаггүй дурсан санах болсон билээ. Хэрэв чи хүсвэл чамд мөн бас нэгэн сонирхолтой түүхийг өгүүлсү.

Ангижралыг хайрлагч ариун мөргөлийн газар Курукшетрад нэгэн цагт нарны бурханы удмаас гаралтай Чандрашарма нэрт хаан амьдран суудаг байв. Нэгэн удаа нар хиртэх үеэр тэрээр нэгэн брахманд өглөг өгөхийг хүсч гэнэ. Энэ өглөг бэлгийн дотор тас хар биетэй нэгэн шудра(ведийн нийгмийн анги давхаргаар энэ нь ажилчин анги) багтаж байв. Өөрийн тахилга үйлдэгчийн хамтаар тэрээр ариун нууранд угаал үйлдээд цэвэрхэн хувцас өмсч, өглөг сэлтээ чин бишрэл сүсэгтэйгээр эрдэмт брахманд барижээ. Өглөг хандивыг өргөн барисны дараагаар мөнөөх хар шудрын зүрхнээс асар нүгэлт чандала(нохойн мах идэгч) гарсан хийгээд дараа нь мөн бас нэгэн эмэгтэй-чандала гарч гэнэ. Тэд брахманд дөхөн очоод гэнэт түүний биенд шингэн оров. Сэтгэлийн тэнцвэрт байдлаа үл алдан, Бурхан Говиндыг дурсан санаж мөнөөх брахман “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийг уншив. Энэ бүхний гэрч болсон хаан юу ч хэлэх тэнхэлгүй гайхан хөшив. “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийн үгс брахманы амнаас дөнгөж урсан гармагц Вишнудудтууд гарч ирээд нөгөөх хоёр чандалыг авч одов гэнэ. Тэгэхээр нь хаан брахманаас асуусан нь: “Өө эрдэмт мэргэн минь, энэ хоёр чухам юун хүмүүс вэ? Ямар мантраг чи уншиж орхивоо?” гэхэд брахман хариулсан нь: “Чандалын биед хувирсан биелсэн нүгэл, алдас доромжлолын биелэл болсон чандала-эмэгтэйн

хамтаар илрэн гарч ирсэн билээ. Тэгээд би хэнийг ч болов хамгийн аймшигт байдлаас авран гаргаж чадах “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийг уншин дуулсан юм. “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийг давтан уншсанаар би цаг ямагт Бурхан Говиндын бадамлянхуан өлмийг дурсан санаж чаддаг билээ”.

Үүнийг сонсоод хаан брахманаас “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийг хэрхэн уншихыг заалгасан хийгээд аажмаар тэрээр Бурхан Говиндын бадамлянхуан өлмийд хүрсэн бөлгөө”.

Ямааны энэ хүүрнэлийг сонсоод Мадхава түүнийг суллан тавьж өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Есдүгээр Бүлгийг давтан унших болсон хийгээд мөн л Бурхан Говиндын бадамлянхуан өлмийд хүрсэн билээ.

10

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Хайрт Парвати минь ээ, одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийн агуу гайхамшгийн талаар ярьж өгье. Энэ түүхийг Лакшми-Деви, өөрөө бурханлаг ертөнцөд хүрэх зам жим болсон Бурхан Вишнугаас сонсож байсан билээ”.

Кашипурт миний хөтөч Нанди мэт надад эрхэм Дхирабуддхи нэрт нэгэн брахман амьдардаг байв. Тэрээр үргэлж амар тайван байдаг байсан хийгээд түүний мэдрэхүйнүүд нь Бурхан Кришнаг магтан алдаршуулахад чиглэгдсэн байдаг байлаа. Түүнийг хаашаа л явна би түүнийг хамгаалах, үйлчлэхийн тулд үлэмж хайр ивгээлтэйгээр түүнийг дагалдаж явдаг байв. Миний үйлдэж буй бүхнийг ажигласан миний мөнхийн албат Бхрингириддхи надаас асуусан нь: “Та түүнд өөрөө үйлчлэн зүтгэх энэ байдалд хүргэх чухам ямар тэвчил наминчлал, ямар буянт үйлийг энэ аугаа чин бишрэлтэн үйлдсэн юм бол?” Бхрингириддхийн энэ асуултанд би ингэж хариулсан юм: “Нэгэн цагт Каилас парватад Пуннагийн цэцэрлэгт Би сарны гэрэлд цэнгэн жарган суув. Гэнэт хүчтэй салхи шуугин үлээж, түүний аймшигт догшин үлээлтээс модод хүртэл ганхаж эхлэв. Гэнэт бүх зүйлсийг уулс халхалсан мэт сүүдэр бүрхлээ. Гэтэл тэнгэрт хур борооны үүл мэт өнгөтэй аварга том шувуу бий болон гарч ирэв. Түүний далавчны дэвэлтийн аясаар модод найгаж, шороон хуй босож байлаа. Шувуу газарт буун ирээд гайхалтай үзэсгэлэнтэй бадамлянхуа цэцгийг өргөн бариад, Надад мэхийн ёслож хэлрүүн: “Ай Мадхава, бүгдийг хамгаалагч Таны алдар бадартугай. Таны яруу алдарт хэмжээ хязгаар гэж үгүй билээ. Та бээр өөрийн мэдрэхүйнүүдээ хянан барисан бүх чин бишрэлтнүүдийг хамгаалж байдаг хийгээд бүх чин сүсэгт бишрэлтэнгүүдийн хувьд Та анхдагч Дээд Бурхан Кришна юмаа. Брихаспати гэх мэт аугаа сүнснүүд хүртэл Таны алдар хүндийг байнгад магтан дуулж байдаг. Олон мянган тэргүүнт Ананта-Шеша хүртэл Таны аугаа алдрыг бүрэн дүүрнээ өгүүлж чадахгүй атал өчүүхэн бодолт шувуу миний бие хэрхэн яаж магтаал өргөх билээ?”

Тэр шувууны залбирал мөргөлийг сонсоод Би түүнээс: “Чи чухам хэн бэ? Хаанаас гараад ирвээ? Чи хун мэт харагдавч бие тань хэрээ мэт хар өнгөтэй юм” хэмээн асуухуйд шувуу хариу өчсөн нь: “Би бол Брахма Тэнгэрийн унаа болох хун гэдгийг мэдтүгэй. Харин миний бие чухам яагаад хар өнгөтэй болсон тухай одоо би ярьж өгье”.

Саураштрын(Сурата) яг зэргэлдээ нэгэн гайхамшигт нуур бий бөгөөд түүнээс энэ гайхалтай бадамлянхуа цэцэг ургасан билээ. Хэсэг хугацаанд би тэнд амарч хэвтээд нисэхээр дөнгөж газраа хөөртөл гэнэт би буцаад газарт уначихлаа. Тэгээд миний бие ийм тас хар өнгөтэй болчихов. Ингээд би яагаад буцаад уначихснаа гайхан эргэцүүлж бодов. Яагаад чухам камфар мэт хар өнгөтэй болчихов? Энэ бүгдийг эргэцүүлэн бодож байтал бадамлянхуа цэцэгт нуурын зүгээс нэгэн дуу гарахыг сонсов: “Хун минь босогтун. Би чиний унаж ойчсон учир шалтгааныг хэлж өгье. Мөн яагаад бие тань хар өнгөтэй болсныг ярьж өгье”. Өндийн босоод би таван гайхалтай гоёмбог бадамлянхуа цэцэг ургасан нуурын төв хэсэг рүү дөхлөө. Тэр цэцгээс нэгэн үзэсгэлэнтэй эмэгтэй гарч ирэв. Түүнийг хүндэтгэлтэйгээр тойроод өөрийнхөө ойчсон шалтгааныг асуулаа. Тэрээр: “Ай хар өнгөт хун минь ээ, тэнгэрт нисэх явцдаа чи над дээгүүр нисэн гарсан билээ. Энэхүү алдас эндлийн уршгаар чи хар өнгөтэй болсон билээ. Чамайг унаж ойчихыг хараад би ихэд өрөвдөж чамайг дуудсан юм. Намайг амаа нээхүйд түүнээс гарах анхилуун үнэр долоон мянган хар зөгийг хоромхон зуурт ариусган чадаад тэднийг хурднаар тэнгэрийн хаант улсад нэвтрэн орох боломжийг олгодог билээ. Ай жигүүртний хаан минь, би чамд өөрийн энэхүү хүчин чадлын учир шалтгааныг тайлбарлан нээж өгье”.

Энэ төрлөөс гурван төрлийн урьдтаа би нэгэн брахманы гэр бүлд төрсөн хийгээд миний нэрийг Сарожавадан гэдэг байв. Эцэг маань намайг цэвэр ариун байхыг ёс зүйд байнгад л сургадаг байв. Нэгэн удаа би майна(хар шувуу) хэмээх шувуу тэжээх болсон хийгээд энэ нь миний нөхөртөө үйлчлэх байдалд маань нөлөөлсөн тул нөхөр маань уурлаж: “Өө тэнэг мулуу эмэгтэй, чи өөрөө майна болтугай” хэмээн хараасан билээ.

Дараагийн төрөлдөө би майна шувуу болон төрөөд цэвэр ариун явдлын ёс жаягийг хатуу баримталдаг байсныхаа ачаар хэдэн их мэргэн хүмүүстэй учрах завшаан тохиосон хийгээд тэд намайг өөрсдийн ашрамд аваачив. Ихэвчлэн намайг тэдний охидуудын нэг нь харж хамгаалдаг байлаа. Тэнд байх хугацаандаа өглөө бүр мөн орой бүр би “Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийг уншихыг сонсдог байв. Үүнийхээ ач тусаар би дараагийн төрөлдөө диваажингийн оронд Падмавати нэрт апсарын биеийг олж төрсөн билээ. Нэгэн удаа цэцгэн хөлөг онгоцон дээр суун аялан явах үестээ энэ нуур дунд ургасан гайхамшигт бадамлянхуа цэцгийг олж харсан юм. Тэгээд тэнд бууж, усанд орж цэнгэн амарч байв. Энэ мөчид их мэргэн Дурваса Муни гарч ирээд намайг чармай нүцгэн байхыг олж харав. Айн мэгдсэн би тэр даруй таван ширхэг бадамлянхуа цэцэг болон хувирлаа. Хоёр гар маань хоёр бадамлянхуа, хоёр хөл маань нөгөө хоёр лянхуа болсон ба биеийн бусад хэсэг маань тав дахь бадамлянхуа цэцэг болсон билээ. Дурваса Мунигийн нүднээс гал бадарч: “Ай нүгэлт эм, чи энэ байрандаа энэ хэлбэрээрээ зуун жил орших болтугай” хэмээн хараагаад алга болон одов. Гэвч аз болоход би мөнөөх “Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийг маргалгүй дурсан санаж явсан хийгээд өнөөдөр чи миний дээгүүр нисч өнгөрсний ачаар би тэр хараалаас ангижирлаа. Чи газар унаж ойчсон хийгээд мөн бие тань хар өнгөтэй болсон ч хэрэв надаас “Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийг сонсох аваас энэ бүхнээсээ ангижирч чадна гэсэн билээ.

“Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийг хэлж дуусаад Падмавати хөлөг онгоцонд суун Вайкунтхийн зүгт хөөрөн одов. Энэ бүхийн дараагаар би энд

хүрэлцэн ирж Танд тэр нуурын гайхамшигт бадамлянхуа цэцгийг өргөн барьж байгаа нь энэ билээ” хэмээв.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Яриагаа төгсгөөд хар хун тэрхэн даруй биеэ орхиж Дхирабуддхийн гэр бүлд мэндэлжээ. Тэрээр хар багаасаа “Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийг давтан уншдаг байжээ. Түүний уншлагыг сонссон хэн бүр гартаа Дун хийгээд Галт хүрд барин байдаг Вишну Бурханы өршөөл хишгийг хүртдэг ажээ. Түүний уншихыг сонссон унан доройтсон хүмүүс буюу архи дарсанд донтогсод, тэр ч бүү хэл брахманыг хөнөөгсөд хүртэл гартаа Дун хийгээд Галт хүрд барьж байдаг Вишну Бурханы адислалыг хүртдэг байв. “Үүний учраас эрхэм Бхрингириддхи минь ээ, би үргэлжид Дхирабуддхид үйлчлэн байдаг билээ”.

Хайрт Парвати минь ээ, хүн эрэгтэй байна уу эмэгтэй байна уу, огоорлын мөр хөөгч байна уу, эсвэл гэр бүлтэн байх зэргээс үл хамааран чухамдаа тэрээр “Шримад Бхагавад гита”-гийн Аравдугаар Бүлгийг давтан унших аваас Бурхан Вишнугийн адис хишгийг хүртэх нь дамжиггүй билээ.

11

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Одоо хайрт Парвати минь ээ, би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийн яруу алдрын талаар ярьж өгье. Түүний бүх алдар сууг бүгдийг өгүүлэх боломжгүй бөгөөд мянга мянган ийм мэт түүхийг нэрлэж болох ч тэдэн дотроос нэгэн түүхийг ярьж өгье”.

Пранита голын эрэгт Меганкара хэмээх хот орших агаад Жагат Ишварын алдар суут нэгэн сүм оршдог ажээ. Жагат Ишвара Шүтээн нь гартаа нум саадаг барьсан байдаг байв. Меганкара хотод бүх амьдралынхаа туршид брахмачари сахилаа хадгалсан Шунанд нэрт брахман амьдран суудаг байжээ.

Шунанд ихэвчлэн Жагат Ишвара Бурханы өмнө завилан сууж “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг давтан уншиж, Бүхний Дээдийн орчлонгийн дүрийг дурсан санадаг байв. “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг давтан уншсанаар тэрээр мэдрэхүйгээ бүрнээ хянан захирч чадаад үргэлжид Жагат Ишвара Бурханыг дурсан санаж чаддаг болжээ.

Нэгэн удаа энэ ариун брахман Шунанд, Годавари мөрний эрэг дагуу орших ариун дагшин газар нутгаар мөргөл үйлдэхээр замд гарчээ. Тэрээр Виража Тиртхагаас авахуулаад бүх л ариун мөргөлийн газруудаар зочлон очсон байна. Явсан газар болгондоо тэрээр угаал үйлдэн тухайн газар нутгийн эзэн шүтээнийг мэлмийдэн харж чаддаг байв. Эцэс сүүлд нь тэрээр Виваха Мандап нэрт хотод хүрэв. Дагалдагч нарын хамтаар буудаллаж болох газар хайж, хотын төвд нэгэн дамшалла буюу амрах газар олж хоноглохоор буудаллажээ. Өглөө сэрээд Шунанд, түүний дагалдагчид цөм алга болсон байхыг харав. Тэднийг хайж олж ядаад тэрээр хотын захирагчтай уулзахаар шийдэн түүний өлмийд сөгдөн юу болсон тухай өгүүлснийн дараа хотын захирагч хариулсан нь: “Ай их мэргэн минь ээ, би өөрийн тань дагуулуудыг хааш одсоныг хэлж мэдэхгүй байна. Гэвч танаас илүү чин сүсэг бишрэлт хүнийг олоход бэрх билээ. Би урьд өмнө тан шиг ийм ариун гэгээн хүнийг харж байсангүй. Эрхэм брахман минь, манай хотод саатан тухлаач” гэв. Хааны хүлцэнгүй даруу гуйлтыг сонсоод Шунанд тэнд хэд хоног байхаар шийдлээ.

Захирагч Шунандыг хотод ая тухтай байлгах бүхий л зүйлийг бүрэн бэлтгэв. Дараа нь өдөр шөнөгүй түүнд үйлчлэн зүтгэв.

Найм хоногийн дараа Шунанд руу нэгэн тосгоны оршин суугч хүрч ирээд чангаар уйлан хайлан өгүүлсэн нь: “Ай ариун гэгээн брахман минь ээ, урьд шөнө миний хүүг нэг ракшас(мангас буюу хүний махан идэштэн, орч.) барьж идэв” хэмээхүйд Шунанд асуусан нь: “Тэр ракшас чухам хаана амьдардаг юм бэ? Яагаад таны хүүг идэх болов?”.

Тосгоны иргэн хариулсан нь: “Манай хотод нэг аймшигт ракшас байдаг билээ. Тэрээр хэзээ дуртай үедээ, дурын өдрөө тосгоны оршин суугчдыг барьж иддэг байлаа. Нэгэн удаа бид түүн дээр хүрч очоод биднийг хайрлаж энэрэхийг гуйж өдөр бүр бид түүнд хүнс залгуулж байх ам тангараг өргөв. Үүний тулд бид нэгэн дамшаллыг барьж, замын аянчин, хэсүүлчдийг тийш нь илгээдэг байсан хийгээд унтаж байх зуурт нь тэднийг энэ ракшас барьж иддэг байсан юм. Ингэж бид өөрсдийгөө хамгаалдаг байв. Та өөрийн дагуулуудтай энэ дамшлалд хоноглон боловч ракшас таныг дагуулуудтай тань хамт идэж чадаагүй. Чухам яагаад ингэснийг би танд тайлбарлаж өгье. Урьд шөнө миний хүү дээр нэг найз нь ирсэн юм. Түүнийг миний хүүгийн их ойр дотны найз эсэхийг би мэдэхгүй л дээ. Иймд түүнийг дамшлал буюу тэр хоноглох газар луу явуулчихлаа. Хүү маань энэ тухай мэдсэн бөгөөд түүнийг буцаахаар ятгаж байтал хэдийнээ дамшлалд хүрчихсэн байжээ. Тэгээд л ракшас түүнийг маань идчихсэн байна. Өнөө өглөө би ракшас дээр очоод яагаад хүүг маань бусад аянчдын хамт идэж орхисон болон түүнийг минь буцааж өгөх арга чарга бий эсэх тухай асуухад, ракшас надад: “Би чиний хүүг дамшлал руу орж ирснийг мэдээгүй. Ийм учраас би түүнийг бусдынх нь хамт идэж орхисон. “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг давтан уншдаг хүний өршөөлөөр түүнийг буцааж авч ирж болох бөгөөд би ч мөн энэ ракшасын биенээс салан ангижирах болно. Одоо энэ хотод, энэ дамшлалд хоноглож байсан нэгэн брахман буй. Тэрээр “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг өдөр бүр уншдаг байсан учраас би түүнийг идээгүй билээ. Хэрэв тэрээр долоон удаа “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг уншаад намайг усаар шүршвэл би энэ ракшасын биед орших хараалаас ангижрах болно” хэмээн хариулав.

Шунанд түүнээс асуусан нь: “Ямар нүгэл үйлдсэний төлөө тэрээр ракшасын биед төрөө вэ” гэхэд тосгоны иргэн: “Их дээр цагт энэ хотод нэгэн фермер амьдардаг байлаа. Нэгэн удаа тэрээр өөрийн талбайгаа харж сахин явж байтал түүний ойролцоохонтой аварга том дэлт бүргэд шувуу замаар явж байсан нэгэн хүн рүү дайрч байхыг харав. Тэр үед түүнээс холгүйхэн нэгэн йогч явж байгаад бүргэд хүн рүү дайрч, нөгөө хүн тусламж аврал эрэн байхыг хараад туслахаар яаран гүйсэн ч хэдийнээ хожимдсон байв. Иймд тэрээр фермерт ихээр уурсан түүнд: “Хэн нэгэнд хулгайч, могой, гал түймэр, зэвсэглэсэн этгээд халдах болон бусад аюул гамшиг нүүрлэн байхыг харсаар атал, мөн түүнд туслах боломж байсаар байтал түүнд үл туславал ийм хүнийг Йамаража цээрлүүлэн шийтгэх бөгөөд тамд удаан хугацаагаар зовж шаналсны эцэст чоно болон төрөх хувьтай билээ. Харин тусламж хэрэгтэй хүнд хэрэгтэй зүйлээр нь тусласан хүн гарцаагүй Бурхан Вишнугийн тааллыг хангадаг. Хэн бээр үнээг араатан амьтны савраас болон доод анги давхаргын хүн буюу хатуу сэтгэлт эзний гараас аврахыг хүссэн хүн бүр зайлшгүйгээр Вишну Бурхан тийш хүрч очих нь лавтай. Харин чи их муу эзэн ажээ. Чи дэлт бүргэд хүн рүү довтолсоор байхыг харсаар мөртлөө түүнийг аврах ямар ч оролдлого хийсэнгүй. Үүний чинь төлөө би чамайг ракшас/мангас/ болон

төрөг хэмээн харааж байна” гэхэд фермер өгүүлсэн нь: “Би бүхэл шөнийн туршид өөрийн талбайгаа харж харгалзан хоноод ихэд ядарсан билээ. Иймээс надад өршөөнгүйгээр хандаж соёрхоно уу, их мэргэн минь ээ” гэсэнд йогч хариулсан нь: ““Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг өдөр бүр унших хэн нэг хүн чиний толгойг усаар шүршвэл чи энэ хараалаас мултрах болно” хэмээв.

Тосгоны оршин суугч өгүүлсэн нь: “Эрхэм Шунанд, иймд та энэ ракшасын толгой руу ус шүршиж хайрлана уу”. Тосгоны суугч эрээс энэ бүхнийг сонсоод Шунанд түүний хамтаар ракшасын амьдардаг газар тийш одов. Ингээд тэрээр “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг давтан уншаад ракшасын толгой руу усаар шүршлээ. Ракшас тэрхэн даруйд Бурхан Вишну мэт дөрвөн мутарт биеийг авсан хийгээд түүнчлэн түүний идсэн бүх хүн цөмөөрөө Бурхан Вишну мэт дөрвөн мутарт бие махбодийг авлаа гэнэ. Дараа нь тэд цөмөөр тэднийг Вайкунтхийн гаригт хүргэхээр илгээгдсэн цэцгэн хөлөг дээр суув.

Энэ гайхалтай үйл явдлыг нүдээр харсан тосгоны тариачин эр түүний хүү аль болохыг ракшасаас асуув. Тэрээр инээмсэглэн трансцендент хөлөг дээр суун буй гайхамшигт бодгалиудаас нэгийг заан: “Хүү тань тэр байна” гэв. Тариачин эр хүүгээ дуудав. Эцгийнхээ гуйлтыг сонсоод хүү хариулсан нь: “Эрхэм нөхөр минь ээ, олон удаа чи миний хүү, олон удаа би чиний хүү явлаа. Гэвч одоо аугаа цэвэр чин бишрэлтэн Шунандын ач тус, өршөөлөөр би өөрийн жинхэнэ гэр Вайкунтхийн зүгт одож байна. Эрхэм нөхөр минь, Шунандын бадамлянхуан өлмийд өөрийгөө даатга, түүнээс “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг сонсон цээжил. Чингэсэнээр чи Бурхан Вишнугийн гаригт/Вайкунтх/ мөн хүрч чадах болно. Үүнд эргэлзэх зүйл үгүй. Энэхүү ариун рашаан мэт сургаал нь Курукшетрийн тулааны талбарт Бурхан Кришнагийн өөрийн найз Аржунагийн асуултанд хариулсан хариултууд билээ. Энэхүү хүүрнэлийг сонсох болон давтан унших төдийгөөр хүн түүнийг үхэх, төрөхийн тойрогт уян барьж байдаг бат бөх зангилааг тасар татан хаяж чадах болно”.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Энэхүү мэргэн ухаан шингэсэн үгийг өөрийн эцэгт хандан өгүүлээд тэрээр бусад аз хийморьтой, цэнгэл жаргалаар бялхан байх сүнснүүдийн хамтаар Вайкунтхийн зүгт одов. Харин түүний эцэг Шунандын тусламжтайгаар “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийг цээжилсэн хийгээд тун удалгүйгээр мөн л Вайкунтхийн зүгт нисэн одов.

Хайрт Парвати минь ээ, ийнхүү чи бүхий л нүглийн үр дагаврыг арилган зайлуулах “Шримад Бхагавад гита”-гийн Арваннэгдүгээр Бүлгийн гайхамшигт алдрын талаар сонсож мэдлээ”.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Арванхоёрдугаар Бүлгийн гайхамшигт алдрын талаар өгүүлэе. Өмнө зүгт Колхапур нэрт нэгэн асар ариун газар бий бөлгөө. Тэнд Бүхний Дээдийн мөнхийн гэргий Маха Лакшмийн сүм оршин байдаг хийгээд Түүнд бүхий л сахиулсан тэнгэрүүд байнгад залбиран мөргөдөг байв. Тэр газарт бүхий л хүсэл биелдэг тийм газар байв. Тэнд мөн Рудрагайа ч оршдог ажээ. Нэгэн удаа тэнд нэгэн залуу ханхүү залран очиж л дээ. Түүний бие алтлаг өнгөтэй хийгээд нүд нь маш үзэсгэлэн төгс, мөр тэгш, цээж хүдэр, урт бахим гартай тийм эр гэнэ. Колхапурт ирээд тэрээр эхлээд

Маникантх-Гиртхийн сүмд хүрч тэнд угаал үйлдэн, өвөг дээдсийнхээ онгодод мөргөв. Дараа нь Маха-Лакшмийн сүмд очиж хүндэтгэл бишрэлээ илэрхийлээд, мөргөн залбирсан нь: “Ай Деви, Таны зүрх энэрэл нигүүлслээр дүүрэн хийгээд гурван ертөнц даяараа Танд мөргөн залбирдаг билээ. Амжилт, аз хийморийг хайрлагч бүтээлийн Эх минь ээ, ай амьд бүхний авран хамгаалагч минь, Таныг магтан алдаршуулъя. Ай бүхий хүслийг гүйцэлдүүлэн биелүүлэгч минь ээ, Та бол бүх гурван ертөнцийг тогтоон барьж байдаг Ачьюта Бурханы гайхалтай эрч хүч билээ. Та бол дээдийн дээд дарь эх билээ, ай чин бишрэлтэнгүүдийн хамгаалагч минь ээ. Таны алдар бадраг. Ай Деви минь ээ, Чухамхүү Та чин бишрэлтэнгүүдийн хүслийг биелүүлдэг хийгээд мөн Та л тэднийг Ачьюта Бурханд үйлчлэн зүтгэх албанд татан оруулдаг билээ. Та мөнх хийгээд унан доройтсон сүнснүүдийг авран чөлөөлдөг. Таны бүхий л алдрыг магтан алдаршуулъя. Ай Деви минь ээ, гурван ертөнцийн сайн сайхан, тэднийг хамгаалахын тулд Та Амбика, Брахма, Вайшнава, Махешвара, Вараха, Маха-Лакшми, Нарасимха, Индра, Кумар, Чандика, Лакшми, Савитра, Чандракала, Рохини, Парамешварийн дүрд хувилан илэрдэг билээ. Яруу алдарт тань хэмжээ хязгаар үгүй Таныг магтан алдаршуулъя. Намайг өршөөн адислаж соёрхоно уу”.

Түүний өргөсөн залбирал Маха-Лакшмид ихэд таалагдсан хийгээд Тэрээр ханхүүд хариу өгүүлсэн нь: “Ай ханхүү минь, Би чиний залбирал мөргөлд сэтгэл ханан талархлаа. Зүрх сэтгэлийнхээ хүсч буй дурын адислалыг Надаас гуйгтун”.

Ханхүү хариу өчсөн нь: “Ай гурван ертөнцийн Эх минь ээ, миний эцэг Брахадратх алдартай ашвамедха тахилга өргөлийг үйлдсэн билээ. Гэвч тэрээр энэ тахилгаа дуусгаж амжилгүй өвчний улмаас таалал төгссөн юм. Харин намайг энэ ашвамедхья-ягьяг/мориор тахил өргөх ёсон, орч/ үйлдэж дуусахын даваан дээр хэн нэг нь бүх дэлхийн өнцөг булан бүрээс авч ирсэн тахил өргөлийн зүйлсийг ариусгах зорилгоор тусгайлан бэлдсэн морийг маань хулгайлчихлаа. Мориныхоо эрэлд би хүмүүсийг энэ дэлхийн бүх хязгаарууд руу илгээсэн авч түүнийг олж чадсангүй. Ингээд Танаас тусламж гуйх зөвшөөрлийг ариун гэгээнтнээс авсан билээ. Хэрэв Та надад сэтгэл ханамжтай буй аваас хэрхэн морио эргүүлэн олж, галан тахилгаа дуусгаж эцгийнхээ тааллыг хангаж болохыг хэлж соёрхоно уу”.

Маха-Лакшми өгүүлсэн нь: “Ай хүндэт ханхүү минь ээ, миний сүмийн хаалган дээр Сиддха-Самадхи нэрт нэгэн их эрдэмт брахман буй. Тэр л чиний хүслийг биелүүлж чадна”.

Маха-Лакшмийн өгүүлэхийг сонсоод ханхүү Сиддха-Самадхид хүрч очин хүндэтгэлээ илэрхийлэв. Хүндэтгэл мөргөлөө илэрхийлж дуусаад алга хавсран түүний өмнө дуугүй зогслоо. Гэтэл Сиддха-самадхи ам нээн: “Чамайг Маха-Лакшми эх илгээсэн ажээ. Иймд би чиний хүслийг биелүүлэх болно” гэв.

Ямар нэгэн мантрануудыг уншаад Сиддха-Самадхи бүх сахиулсан тэнгэрүүдийг өөртөө дуудан авч ирэв. Сиддха-Самадхийн өмнө зогсоод, түүний заавар тушаалыг хүлээн байхыг ханхүү харлаа гэнэ. Энэ бүгдийн дараагаар Сиддха-Самадхи хэлсэн нь: “Тэнгэрүүд минь ээ, Энэ ханхүүгийн тахил өргөхөөр бэлдсэн морийг урьд шөнө Индра Тэнгэр хулгайлжээ. Тэр морийг нааш авч ирж өгнө үү”.

Сахиулсан тэнгэрүүд тэр даруй түүний өмнө морийг авчирсан бөгөөд дараагаар нь Сиддха-Самадхи тэднийг явуулав. Ийм гайхмаар дүр зургийг харсан ханхүү түүний өлмийд сөхрөн унаж, асуусан нь: “Хэний ч эзэмшиж байгаагүй, миний урьд өмнө харах хийгээд сонсож ч байгаагүй энэ их хүч чадлыг та хэрхэн олоо вэ?”

Миний гуйлтыг сонсож болгооно уу, аугаа мэргэн минь ээ, Миний эцэг Брахадратх ашвамедха тахилгаа дөнгөж эхлүүлээд өөрөө гэнэт таалал төгссөн билээ. Иймээс би түүний биеийг цэвэр буцламгай тосонд хадгалж байдаг. Хэрэв та хүсвэл түүнийг буцаан амьдруулж өгөөч”.

Үүнийг сонсоод Сиддха-Самадхи зөөлөн инээмсэглээд хэлсэн нь: “Таны эцгийн бие байгаа газар тийш явцгаая” гэв. Тэнд хүрээд Сиддха-Самадхи гартаа жаахан ус утгаж аваад нэгэн мантраг давтан уншсаны дараагаар үхсэн Брахадратха хааны толгой руу цацав. Ус хааны толгойд хүрмэгц хаан босч суугаад Сиддха-Самадхигаас: “Аугаа чин бишрэлтэн минь ээ, та хэн бэ?” хэмээн асуухад ханхүү тэр даруй эцэгтээ болсон бүх явдлыг яриу. Энэ бүгдийг сонсоод хаан Сиддха-самадхид дахин дахин хүндэтгэлээ илэрхийлээд ийм аугаа бурханлаг хүч чадалд хүрэхийн тулд тэрээр чухам ямар тэвчил наминчлалыг үйлдсэн тухай лавлан асуув. Хааны асуултын хариуд Сиддха-Самадхи хариулсан нь: “Эрхэм Брахадратха хаан минь ээ, би өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Арванхоёрдугаар Бүлгийг уншдаг билээ” гэв.

Аугаа чин бишрэлтний энэ үгийг сонсоод хаан Сиддха-самадхийн туслалцаатайгаар “Шримад Бхагавад гита”-гийн Арванхоёрдугаар Бүлгийг цээжилсэн хийгээд аажмаар хаан болон түүний хүү хоёул бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд хүрсэн билээ. Өөр бусад олон олон бодгалиуд өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Арванхоёрдугаар Бүлгийг давтан уншсанаар амьдралын дээд зорилго болох Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд хүрсэн бөлгөө.

13

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Ай Парвати минь, “Шримад Бхагавад гита”-гийн Арвангуравдугаар Бүлгийн хэмжээлшгүй алдрын талаар сонсогтун, үүнийг сонссоноор чи маш их аз жаргалтай болж чадна”.

Өмнө зүт Тунгабхадра нэрт том мөрөн оршдог бөгөөд түүний эрэг дээр үзэсгэлэнт хот Харихарпур сүндэрлэх бөлгөө. Тэнд Харихар хэмээн алдаршсан Шива Тэнгэрийн Шүтээнд мөргөдөг хийгээд Түүнийг үзэж харсан хэн бүхэн буянт үйлсийн бүхий л зорилгодоо хүрдэг ажээ.

Харихарпурт маш их эрдэм мэдлэгтэй, энгийн хатуу амьдралын хэв маягийг мөрддөг Харидикшит нэрт брахман амьдардаг байв. Түүний эхнэрийг Дурачара гэдэг байсан агаад тэрээр бузар буруу үйлэнд автсан нэгэн байжээ. Өөрийн нөхөртэйгээ зүй бусаар харьцдаг байсан ба хэзээ ч түүнтэй унтаж байсангүй. Нөхрийнхөө найзуудтай тэрээр байнгад бүдүүлгээр харьцдаг байсны дээр өөрийн хүсэл тачаалыг хангахын тулд бусад эрчүүдтэй уулзалддаг байв. Үүнээс гадна тэрээр мансууруулах бодист дурлан татагдах болсон бөгөөд хотын хүн ам нэмэгдэхийн хирээр тэрээр ойд нэгэн урц овоохой барьж тэндээ нууц амрагуудтайгаа учрах болжээ. Нэгэн удаа урц овоохойд нь хэн ч ирээгүй байсан тул шунал тачаалдаа автсан тэрээр өөрийн тачаалт хүслийг хангах хэн нэгэнтэй учрах болов уу хэмээн найдаж ойгоор хэрэн хэсүүчилж явав. Хэсэг хугацааны дараа өөрийн шунал хүслийг хангаж үл чадсаны улмаас бие махбодь, мэдрэхүй,

ухаан санаа зэрэг нь тэвчээрийн эцсийн цэгтээ хүрснийг ойлгоод тэрээр сулбайн суугаад цурхиран уйлж эхлэжээ.

Түүний уйлах дууг сонсоод нэгэн өлсгөлөн бар зүүрмэглэх нойрноос сэрж дуу гарсан зүг рүү яаравчлан харайв. Хэн нэгэн ойртон ирэх чимээг сонсоод тэр тачаангуй эмэгтэй түүний адгуусны хүслийг хангах хэн нэгэн хэмээн бодоод үсрэн боссон авч тэрээр өмнө нь өлсгөлөн бар зогсож байхыг харлаа. Өөрийн хурц хумсаар тэрээр түүнийг хэдэн хэсэг болгон тасдан хаяхад бэлэн зогсох ажээ.

Тэгмэгц шунал хүсэлт эмэгтэй түүнд хандан: “Бар минь ээ, чи яагаад намайг хөнөөхөөр ирэв? Эхлээд үүнийгээ тайлбарла. Харин дараа нь зооглож болно” гэв. Араатны хаан Дурачарын асуултанд түр түдгэлзэн тээнэглэсэн зогсоод инээмсэглэн түүнд ийм нэгэн түүхийг ярьж өгчээ.

“Өмнө зүгт Малапаха нэрт мөрөн орших ба түүний эрэгт Мунипарна нэрт хот орших авай. Тэнд Шива Тэнгэрийн алдарт Шүтээн Панчалинга орших бөгөөд энэ хотод би нэгэн брахманы гэр бүлд төрсөн билээ. Хэдий тийм тэнгэрлэг сайхан гэр бүлд төрсөн ч би тун ч их хомхой сувдаг байсан ба өөрийн мэдрэхүйгээ хянан барьж чаддаггүй байв. Тэнд би нэгэн гоын эрэг дээр суугаад тахилга өргөл үл үйлдэж чадах хүмүүст зориулан тахилга үйлддэг байлаа. Түүнээс гадна материаллаг үзэл бүхий хүмүүсийн гэрт хооллож ундалдаг байсан хийгээд тахилга өргөл үйлдэх болон шүтээндээ үйлчлэхэд шаардлагатай хэмжээнээс илүү мөнгийг хураан цуглуулдаг байв. Мөн би зохицуулах зарчмуудыг хатуу мөрддөг брахман хүмүүсийг муушаан доромжилдог байсны дээр хэзээ ч өглөг хишиг өгч байсангүй. Насны эрхээр хөгширч, үс минь цайж, шүд маань унаж, нүд маань муудлаа. Гэвч тэр мөчид ч би мөнгө хөрөнгө хурааж хуримтлуулах шуналаа орхисонгүй. Нэгэн удаа хоол хүнс гуйхын тулд би санамсаргүй догшин хатуу, чадал хүч ихтэй брахмануудын мэх заль луйвар дээр таарчихсан ба намайг нохойнууд руу хөөн гаргасан юм. Нохдын нэг нь миний хөлнөөс хазсан бөгөөд би өнхрөн унаж, удалгүй үхсэн билээ. Ингээд би бар болон төрөөд энэ аюул ослоор дүүрэн ойд амьдарч байна.

Аз болоход би өөрийн урьд төрлөө дурсан санадаг бөгөөд чин бишрэлтэн, санньяса, энгийн эмэгтэйчүүд рүү үл дайрах бүлгээ. Би зөвхөн нүгэлтнүүдийг зоог болгон иддэг ба мэдээж ийм зохимжгүй эмэгтэйг идэх нь лавтай. Чи бол хамгийн олиггүй, нүгэлт эмэгтэй тул би даруй миний өглөөний зоог болох болно” гэв.

Энэ бүгдийг ярьж гүйцээд бар ов ихтэйгээр нүгэлт эмэгтэйг идэж орхив. Үүний дараагаар Йамадутууд түүнийг хүний өтгөн, шингэн, цус мэтээр дүүргэсэн нуур Дуйада там руу илгээжээ. Тэрээр энэ гутамшигт газарт 10 сая кальпыг дуусан дуустал оршин байсан агаад дараа нь түүнийг зуун манвантарын туршид Раурава тамд илгээсэн ба үүний дараагаар дахин Дэлхийдээ чандала-эмэгтэй болон төрсөн билээ. Гэвч тэрээр мөн л урьдних шигээ нүгэлт үйлүүдийг үйлдэн амьдарсаар байв. Нүгэлт үйлийнхээ уршгаар тэрээр уяман буюу нойтон хамуу өвчин болон сүрьеэ өвчнөөр өвджээ. Нэгэн удаа тэрээр азаар Харихарпурын ариун газар орноо одож, Жамбакадевийн(Парвати) сүмийн ойролцоо “Шримад Бхагавад гита”-гийн Арвангуравдугаар Бүлгийг байнгад хүүрнэн унших ариун гэгээн Васудеватай учирчээ. Түүний амнаас сонссон хүүрнэл түүнийг ихээр татаж, дахин дахин сонсон байсан ба энэ нь түүнд чандалын биеийг орхих, өөрийн нүгэлт үйлийн үр дагавраас бүрнээ ангижрах боломжийг олгосон байна. Тэрээр Бурхан Вишну мэт дөрвөн мутарт биеийг хүлээн авсан ба Вайкунтхийн зүгт халин одвой.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Ай Парвати минь ээ, миний өгүүлэх “Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийн яруу алдрын талаар маш анхааралтайгаар сонсогтун”. Симхадвипад Викрам-Бетаал нэрт нэгэн хаан амьдран суудаг байжээ. Нэгэн удаа тэрээр ан хийхээр явах болж түүндээ өөрийн хүү болон хоёр анч нохойгоо дагуулан явав гэнэ. Ойд хүрээд тэрээр хоёр нохойныхоо нэгийг нэгэн молтогчин туулайн араас тавив. Нохойд хөөгдсөн туулай гүйх биш яг л нисч буй мэтээр зугатав гэнэ. Ойн гүн рүү улам улам нэвтрэн орж тэрээр ариун гэгээн даяанч нар амьдардаг аглаг зэлүүд, үзэсгэлэнтэй сайхан, тайван амгалан газарт хүрэв. Тэнд модны сүүдэр дор буга тайван хэвтэх агаад сармагчингууд модноос жимс түүн бувганан идэх ажээ. Барын зулзага зааны зулзагатай тоглон байх бөгөөд могой тогоснууд дундуур мурилзан мөлхөж байв. Энэ ойд “Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийг давтан уншиж, Бурхан Кришнад мөргөн залбирдаг Ватса нэрт мэргэн амьдардаг байлаа. Махаража Ватсийн ашрамын ойрхонтой түүний шавь нарын нэг “Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийг уншин, хөлөө угаан сууж байсан ба түүний эргэн тойрон дахь газар шал нойтон болсон байлаа. Үүний дараагаар тэр газар дээгүүр нөгөөх молтогчин харайн өнгөрч байгаад хальтиран унаж тэрхэн дороо тэнгэрийн биеийг авлаа. Тэрхэн даруйд тэнгэрээс нисдэг хөлөг буун ирээд түүнийг тэнгэрийн орноо авч одов. Агшин зуурын дараа туулайг хөөн байсан мөнөөхь нохой давхин гарч ирээд мөн л хальтирч ойчоод тэнгэрийн биеийг авч мөн л тэнгэрийн орноо одов.

Энэ бүгдийг хараад Махаража Ватсийн шавь хөгжин инээмсэглэв. Энэхүү гайхалтай үйл явдлын гэрч болсон Викрам-Бетаал хаан брахманаас асуусан нь: “Молтогчин, нохой хоёр хэрхэн яаж бидний нүдэн дээр тэнгэрийн орноо одов ?” гэхэд брахман хариу өгүүлсэн нь: “Энэ ойд аугаа мэргэн Ватса амьдардаг бөгөөд тэрээр өөрийн мэдрэхүйнүүдээ бүрнээ хянан захирч чадсан хийгээд байнгад “Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийг давтан уншдаг юм. Би түүний шавь бөгөөд түүний өршөөлөөр мөн л “Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийг давтан уншихад цаг заваа зориулдаг билээ. Молтогчин, нохой хоёр хальтирч ойчсон тэр газрыг миний өлмийгөө угаасан ус нойтон болгосон байсны ачаар тэр хоёул дээд гаригст хүрсэн юм. Харин одоо би яагаад инээсэн учраа тайлбарлая. Махараштрад, Пратудхак нэрт хот орших агаад тэнд Кешава нэрт брахман амьдардаг байлаа. Тэрээр их хатуу догшин нэгэн байсан бөгөөд эхнэрийг нь Вилобхана гэдэг байв. Тэр эмэгтэй ёс журамгүй нэгэн байсан хийгээд байнгад олон эрчүүдтэй цэнгэн жаргадаг байжээ. Үүний улмаас нэгэн удаа нөхөр нь ихээр уурлан хилэгнэж, түүнийг хөнөөсөн бөгөөд дараагийн төрөлдөө тэрээр нохой болон төрсөн байна. Харин брахман Кешава нүгэлт үйлийнхээ уршгаар молтогчин туулай болон төрсөн юм”.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: ““Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийн алдар сууг сонсоод Викрам-Бетаал хаан мөн өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Арвандөрөвдүгээр Бүлгийг унших болов. Бие махбодио орхин нас нөгчихийн цагт тэрээр Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд мөнхөд үйлчлэхээр Вайкунтхийн зүгт нисэн одвоо”.

Шива Тэнгэр өгүүллүүн: “Хайрт Парвати минь ээ, одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Арвантавдугаар Бүлгийн яруу алдрын талаар ярьж өгье. Анхааралтайгаар сонсогтун”.

Гаудадашед Крипан-Нарасимха нэрт нэгэн хаан амьдардаг байлаа. Тэрээр сахиулсан тэнгэрүүдийг ч ялан дийлэх чадвартай тийм их хүч чадалтай хаан байсан бөгөөд түүний цэргийн хүчний удирдагчийг Сарабхмерунд гэдэг байв. Тэрээр маш их хомхой шунаг сэтгэлт нэгэн байсан тул нэгэн хунтайжтай нэгдэж хааныг хорлоод өөрөө Гаудадашийн эзэн болохыг санаархаж байжээ. Гэвч тэрээр бодож төлөвлөсөнөө гүйцээж чадалгүй гэдэсний хижгээр өвчлөн байсаар удалгүй нас нөгчжээ. Үхсэнийхээ дараагаар тэрээр Синдху нутагт нэгэн морь болон шинэ төрлийг авч гэнэ. Тэр морь маш гоёмсог үзэсгэлэнтэй, хурдан хүлэг байсан хийгээд уралдаан тэмцээнд байнгад түрүүлэгч хүлэг морины бүх шинжийг өөртөө шингээсэн байв. Нэгэн удаа энэ морийг Гаудадашийн томоохон баяны хүү хараад түүнийг худалдан авч Гаудадашийн хаанд арилжих санаа төржээ. Тэгээд хот орж, шууд л хааны ордныг зүглэн очоод, хаалгачаас түүний ирсэн тухай хаанд дамжуулахыг хүсэв.

Ингээд хаантай ч уулзсан бөгөөд хаан түүнээс ирсэн хэрэг зоригийг нь лавлалаа. Худалдаачин хариулсан нь: “Ай хаантан минь, Синдхууд би бүх орчлон даяар олохын аргагүй тийм гайхамшигтай шинж бүрдсэн нэгэн хүлэг морийг олсон билээ. Тэгээд би түүнийг их өндөр үнээр худалдаж авсан юм” гэв. “Тэр морио даруй авч ир” хэмээн хаан зарлигдав. Морийг удаж төдөлгүй хаанд авч ирж үзүүлсэн агаад хурдан хүлгийн гоц гойд шинж байдал хаанд ч ихэд таалагджээ. Түүнийг үзэж шинжиж гүйцээд удаан ч бодсонгүй худалдаачны хэлсэн үнээр мөнөөхь морийг худалдан авчээ.

Хэд хоногийн дараагаар хаан анд явахаар шийдэв. Тэгээд хаан шинэхэн худалдан авсан хүлгээ унан нэгэн ойд ортол бугатай таарч, ухаан жолоогүй түүнийг элдэн хөөв. Тэрээр бугыг хаашаа л зугадана, түүний мөрийг нь мөшгин элдэнэ. Бараа бологч нар нь хаа хол ард нь үлдэж хоцров. Бугыг удаан хугацааны туршид элдэн хөөсөөр ядран, ангаж цангасан тэрээр амрахаар буун саатлаа. Морио модны мөчрөөс уяж орхиод өөрөө нэгэн чулуун дээр сандайлан суув.

Хэсэг хугацаанд амран сууж байтал чулуун дээр салхинд хийссэн нэгэн тослог цаас унахыг харжээ. Энэхүү цаасны өөдсөн дээр “Шримад Бхагавад гита”-гийн Арвантавдугаар Бүлгийн нэг шүлэгний хагасыг бичсэн байв. Хаан түүнийг уншихыг оролдон байсан ба шүлгийн дөнгөж эхний авиа хааны амнаас гаргал морь газарт хөрвөөн унаж, биеэ орхин трансцендент дөрвөн мутарт биеийг аваад тэрхэн даруйд түүнийг Вайкунтхийн трансцендент ертөнц рүү авч одохоор ирсэн цэцгэн хөлөг дээр суусан байлаа.

Тэднээс холгүйхэн жимст моддоор хүрээлэгдсэн нэгэн үзэсгэлэнтэй сайхан ашрам байхыг хаан ажиглав. Түүнд өөрийнхөө мэдрэхүйнүүдийг бүрнээ хянан эзэмдэж чадсан нэгэн брахман амьдардаг ажээ. Хаан түүнд хүндэтгэл бишрэлээ илэрхийлэн мөргөөд, алга хавсран байж асуусан нь: “Чухам ямар учраас морь маань Вайкунтхийн зүгт одох болов ?” хэмээхэд Вишнушарма нэрт мөнөөхь брахман хариу өчсөн нь: “Ай хаан минь, Чамд нэгэн цагт Сарабхмерунд нэрт

армийн тань удирдагч нэгэн хүн байсан биз. Ханхүүтэй үгсэн хуйвалдаж тэрээр чиний хаан ширээг булаан авахыг санаархаж байсан юм. Гэвч энэ төлөвлөгөөгөө гүйцээж амжилгүй гэдэсний хижиг өвчнөөр өвдөж нас нөгчсөн бөгөөд үхсэнийхээ дараагаар энэ морь болон төрсөн билээ. Тохиолдлоор “Шримад Бхагавад гита”-гийн Арвантавдугаар Бүлгийн хэдхэн үгийг сонссон төдийгөөр тэрээр Вайкунтхийн зүгт одлоо” гэв.

Хаан, брахманд хүндэтгэлээ илэрхийлээд нийслэл хотын зүгт буцан очоод нөгөөх цаасан дээр бичигдсэн тэр зүйлийг нэг бус удаа уншив. Хэсэг хугацаа өнгөрсний дараагаар хаан Гаудадешийн хаанаар өөрийн хүүгээ тохоон томилоод өөрөө “Шримад Бхагавад гита”-гийн Арвантавдугаар Бүлгийг байнга давтан уншихаар ой модыг зүглэв. Ингээд тэрээр тун ч хурднаар Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд хүрсэн билээ.

16

Шива Тэнгэр айлдсан нь: “Одоо би чамд “Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгийн гайхамшигт алдрын талаар ярьж өгье”.

Гужаратад Сурастра(Сурат) нэрт хот бий бөлгөө. Тэр хотод Кхандгабаху хэмээх хаан өөрийн хаант улсыг захиран суух бөгөөд тэр улс орондоо тэрээр яг л тэнгэрийн хаан Индра мэт элбэг хангалуун амьдрах ажээ. Тэр хаанд Аримардана нэрт нэгэн галзуу догшин заан байх бөгөөд хөөрөн бардамнахын улмаас түүний чамархайнаас ус гоожин байдаг байв. Нэгэн удаа галзуу нь хөдөлсөн заан торноосоо мултран гарч, өөрийн амьдарч асан байраа эвдэн нураагаад хотын оршин суугчдыг элдэн хөөж тал тал тийш тонгочин харайв. Бүгд л тал тал тийш аль болох хурдан гүйн зугадна. Зарц албат нар болж буй бүгдийн тухай хаандаа уламжилсан бөгөөд түүнийг сонссон хаан хүүгийн хамт галзуурсан зааны байгаа газар тийш явав. Кхандгабаху хаан зэрлэг зааныг залан удирдах эрдмийг эзэмшсэн нэгэн байсан ба галзуурсан зааныг хайх явцад тэрээр зааны хөлд гишгэгдсэн болон амиа аврахаар зүг бүрт зугадан буй олон олон хүнийг харлаа. Энэ үймээн бужигнаан дундуур, тэр цаг мөчид, тэрээр нууранд угаал үйлдчихээд буцан тайван алхаж яваа нэгэн брахманыг ажиглав. Тэр брахман *абхайам* (аймшиггүй) хэмээх үгээр эхлэх Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгийн эхний гурван шүлгийг намуухнаар давтан унших ажээ. Заанд дөхөн яваа брахманыг хараад хүмүүс түүнийг заанд ойртуулахгүй байхыг оролдсон боловч брахман тэднийг үл анхааран галзуурсан заан руу хүрч очоод түүнийг гараараа илэн аргадав. Хажууд нь хүрч ирсэн брахманыг харсан заан тэрхэн дороо уур омог нь дарагдан хэвтээд өгөв. Түүнийг хэд хэд зөөлөн алдгадаад брахман цааш замаа үргэлжлүүлэв. Энэ гайхалтай үйл явдлын гэрч болсон хаан болон хотын бусад бүх иргэд гайхан алмайрлаа. Хаан брахманы хөлд сөгдөн асуусан нь: “Ийм амгалан тайван байдал хийгээд гайхалтай хүч чадалд хүрэхийн тулд та ямар тэвчил наминчлал, үйлчлэлийг хийсэн бол?” гэхэд тэрээр хариулсан нь: “Би өдөр бүр Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгээс хэдэн шүлэг уншдаг билээ” гэв.

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Хаан брахманыг ордондоо урин залсан агаад тэнд тэрээр түүнд зуун ширхэг алтан зоосыг өглөг болгон өргөж, тэр буянт брахманаас “Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгийн шүлгүүдийг унших сургаал зөвлөгөөгөө хайрлахыг хүсэн гуйв.

Хэсэг хугацаанд эдгээр шүлгүүдийг уншаад нэгэн удаа Кхандгабаху хаан хамгаалагчийн хамтаар галзуу заан руу хүрэлцэн очоод түүнийг харгалзан байдаг зарц албатуудад зааныг суллан тавихыг даалгав. Заан дахин догшрон галзуурах вий хэмээн хааны хийж буй үйлдэлд хотын иргэд түгшин догдлов. Хааныг галзуу зааны өмнө явж очиход тэрээр тэрхэн даруйд хэвтээд өгсөн бөгөөд хаан ч түүнийг гараараа илбэн таалав. Үүний дараагаар тэрээр ордон руугаа буцаж өөрийн хүүгээ хаан ширээнд өргөмжлөөд өөрөө “Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгийг давтан уншиж Бурхан Кришнад мөргөхөөр ой руу одсон ба тун ч хурднаар Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд хүрсэн билээ.”

“Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгийг давтан унших хэн бүр хэдий их нүгэл хилэнцтэй байсан ч Кхандгабаху хааны хүрсэн тэр зорилго болох Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд тун хурднаар хүрэх бөлгөө.

17

Шива Тэнгэр өгүүлсэн нь: “Хайрт Парвати минь ээ, чи “Шримад Бхагавад гита”-гийн Арванзургаадугаар Бүлгийн хязгааргүй алдрын тухай дуулж мэдлээ. Одоо харин “Шримад Бхагавад гита”-гийн Арвандолоодугаар Бүлгийн рашаан мэт алдрыг сонстугай”.

Кхандгабаху хааны хүүд заль мэх, олиггүй муу зан ааш бүхий Душасан нэрт зарц бий бөлгөө. Душасан нэгэн удаа заан унаж чадна хэмээн ханхүүтэй маргалдан мэтгэлцсэн бөгөөд тэрээр шууд л түүн дээр харайн мордсон авч хэдэн алхам явсны дараагаар хүмүүс түүнийг тэр аюулт заанаас унуузай хэмээн сэрэмжлүүлэн хашгиралдав. Гэвч бодлого ухаан муут Душасан зааныг давиран, бүдүүлэг үгсийг урсган хурдан явахыг шавдууллаа. Гэтэл гэнэт зааны уур хилэн бадран ийш тийш зэрлэгээр тонгочин харайв. Нуруун дээр нь удаан тогтож тэсэлгүй Душасан газарт ойчсон бөгөөд заан ч түүний дээгүүр гишгэлэн өнгөрөв. Ингээд Душасан ч үхэж гэнэ. Үхсэнийхээ дараагаар тэрээр Симхадвипад нэгэн заан болон төрсөн агаад хааны ордонд амьдрах болжээ. Симхадвипын хаан, Кхандагабаху хааны их дотнын найз нөхөр байсан бөгөөд нэгэн удаа тэрээр энэ заанаа өөрийн найз Кхандгабаху хаанд бэлэглэхээр шийдэв. Бэлгийг хүлээн авсан Кхандгабаху хаан өөрт нь шүлэг яруу найраг нь ихээр таалагддаг нэгэн яруу найрагчид бэлэглэжээ. Харин яруу найрагч зааныг зуун алтан зоосоор Мальвын хаанд худалдаж гэнэ. Хэсэг хугацаа өнгөрсний дараагаар заан үл эмчлэгдэх айхтар хүнд өвчнөөр өвчилсөн бөгөөд үүнийг мэдсэн хаан түүнийг аван нэгэн сайн эмчид үзүүлэхээр явлаа. Энэ үед хааныг ихээр балмагдуулан гайхуулж, заан өгүүлсэн нь: “Хүндэт хаан минь, чи маш их буянт агаад Ведийг хатуу баримтлах ажээ. Мөн цаг үргэлжид Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд мөргөн залбирах юм. Ийм учраас эм тан хийгээд эмч домчийн аль нь ч үр ашиггүй гэдгийг мэдэгтүн. Түүнчлэн ямар ч төрлийн буянт үйл болон тахилга өргөл үхэх цаг мөчид тус болохгүй билээ. Хэрэв чи үнэхээр миний төлөө санаа зовниж буй хийгээд надад туслахыг хүсэж буй бол өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Арвандолоодугаар Бүлгийг уншигч хүнийг олж авчрагтун” хэмээв.

Зааны хүссэнээр хаан “Шримад Бхагавад гита”-гийн Арвандолоодугаар Бүлгийг тогтмол унших нэгэн аугаа чин бишрэлтнийг урин залсан агаад тэр чин бишрэлтэн Арвандолоодугаар Бүлгийг унших явцад зааныг усаар шүрштэл тэрхэн мөчид заан

өөрийн зааны биеэ орхин Бурхан Вишну мэт дөрвөн мутарт биеийг авав. Ингээд л тэрхэн даруйд түүнийг Вайкунтхийн зүгт авч одохоор хүрэлцэн ирсэн цэцгэн хөлөгт суусан байлаа. Түүнийг хөлөгт хэдийн суусны хойно хаан түүнээс урьд төрөлдөө чухам хэн байсныг нь лавлан асуухуйд, Душасан түүнд урьдны бүх түүхээ ярьж өгөөд Вайкунтхийн зүгт одов. Энэ бүх үйл явдлын дараагаар хүмүүсийн сор болсон Мальвын хаан мөн “Шримад Бхагавад гита”-гийн Арвандолоодугаар Бүлгийг давтан унших болсон бөгөөд тун ч хурднаар Бурхан Кришнагийн бадамлянхуан өлмийд хүрсэн билээ.

18

Парвати өгүүлсэн нь: “Хайрт нөхөр минь ээ, чи “Шримад Бхагавад гита”-гийн Арвандолоодугаар Бүлгийн яруу алдрын талаар ярьж өглөө. Одоо харин “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийн алдрын талаар ярьж өгнө үү”. Шива Тэнгэр хариу өгүүлсэн нь: “Ай Гималайн охин Парвати минь, Ведээс дээгүүрт орших, хязгааргүй жаргал цэнгэлийг бэлэглэх “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийн тухай хүүрнэлийг одоо сонсоно уу”. Хэрэв тэрээр хүний чихээр нэвтрэн орвол түүний бүх материаллаг хүслийг устгах бөлгөө. Энэ бол цэвэр чин бишрэлтэнгүүдийн хувьд бурханлаг рашаан, Бурхан Вишнугийн амь амьдрал, Индра Тэнгэр болон бусад сахиулсан тэнгэрүүд, мөн Санака, Сананда тэргүүтэй аугаа йогчдын зүрх сэтгэлийг амирлуулан тайвшруулах зүйл билээ.

Йамаражийн элч нар түүнийг давтан уншиж байгаа хүнээс дөлөн тойрох бөгөөд тийм богино хугацаанд бүх нүгэл хилэнцийг устган зайлуулах, хүмүүнийг энэ ертөнцийн гурвалсан зовлонгоос ангижруулах өөр ямар нэг уншлага үгүй билээ. Тиймд одоо асар их итгэл бишрэлтэйгээр миний өгүүлэхийг сонсогтун.

Меру уулын хамгаас өндөр оргил дээр Вишвакарма(сахиулсан тэнгэрүүдийн архитектор), Амаравати хотыг барьж байгуулсан бөлгөө. Энэхүү тэнгэрийн хаант улсад сахиулсан тэнгэрүүд бүгдээр Индра Тэнгэр хийгээд түүний эхнэр Шачи нарт үйлчлэн зүтгэдэг байлаа. Нэгэн удаа Индра Тэнгэр амар тайван залран сууж байтал түүний зүг нэгэн маш гайхамшиг төгс бодгаль ойртон ирэхийг гэнэт харав. Түүнд Вишну Бурханы албатууд үйлчлэн зүтгэх ажээ. Энэхүү гайхамшигтай, залуухан бодгалийг хармагц Индра Тэнгэр өөрийн сэнтийгээс шуудхан буун газарт сөхрөн унав. Энэ үед түүнд үйлчлэн байдаг сахиулсан тэнгэрүүд түүний өмсдөг титмийг гэнэт бий болсон мөнөөх бодгалийн тэргүүнд зүүлээ. Дараа нь бүх сахиулсан тэнгэрүүд болон тэнгэрийн орны оршин суугчид аратика ёслолыг үйлдэн шинэ Индра хаанд зориулан уянгат тансаг дууг дуулав. Энэ үед аугаа даяанч, арш нар хүрэлцэн ирж Ведийн мантрануудыг уншин өөсрдийн адис ерөөлөө хайрласан бөгөөд гандхарва болон апсарууд баяр хөөртэйгөөр дуулан бүжиглэлдлээ. Тийнхүү шинэ Индра хаан зайлшгүй үйлдэх ёстой зуун мориор тахилга өргөлгүйгээр сахиулсан тэнгэрүүд хийгээд тэнгэрийн орны оршин суугчдын үзүүлэх олон төрлийн алба үйлчлэлийг хүртэн цэнгэн суув. Харин өмнөх Индра энэ бүгдийг хараад ихэд гайхлаа.

Тэрээр бодсон нь: “Энэ этгээд хэзээ ч худаг гаргаж, нуур цөөрөм тогтоож байсангүй, мөн бусдын сайн сайхны төлөө мод тарьж байгаагүй, ган гачиг болоход үр тариаг өглөг болгон тарааж байгаагүй, бас тэрээр хэзээ ч ямар нэг галан тахилга

болон буянт үйлийг үйлдэж байгаагүй. Гэтэл тэр хэрхэн яаж миний байр суурийг эзлэх болов ?”. Хуучин Индра, түүний ухаан бодол нь маш ихээр түгшин долгилохыг мэдрээд Бурхан Вишнуд залбирал өргөхийн тулд сүүн далайг зүглэн одлоо. Ингээд түүнд Бурхан Вишнугийн дүрийг харах завшаан тохиосон бөгөөд тэрээр Түүнээс асуусан нь: “Эрхэм хүндэт Вишну Бурхан минь ээ, урьд өмнө би тэнгэрийн орны эзэн болохын тулд маш олон тахилга өргөл хийгээд бусад төрлийн буянт үйлийг олныг үйлдэж асан билээ. Гэтэл энэ удаад тэнд өөр нэгэн этгээд очин миний миний эзэн хааны байр суурийг эзлэн суух болов. Тэрээр амьдралдаа хэзээ ч томоохон, гайхалтай буянт үйлийг үйлдэж байгаагүй бөгөөд ведийн ямар нэгэн томоохон өргөл тахилгыг үйлдэж байгаагүй. Гэтэл хэрхэн яаж тэрээр миний ширээнд суух болов ?” гэхэд Вишну Бурхан хариу айлдсан нь: “Эрхэм Индра минь ээ, энэ аугаа сүнс нь өдөр бүр “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийг давтан уншдаг асан билээ. Бүх амьдралынхаа туршид тэрээр өдөр бүр энэ бүлгээс таван шүлэг давтан уншдаг байсан юм. Үүний ач тусаар бүхий л төрлийн буянт үйл болон тахилга өргөлөөс хүртэх үр дүнг амсаж буй нь энэ. Тэнгэрийн хааны суудалд он удаан жилээр залран суусны дараагаар тэрээр Миний мөнхийн гариг орноо хүрэлцэн очих болно. Хэрвээ чи мөн “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийг давтан унших аваас мөн л Миний мөнхийн бурханлаг орноо очих болно” гэв.

Вишну Бурханы үгийг сонсоод, Индра Тэнгэр брахманы дүрд хувиран Годавари мөрний эргийг зүглэн одсон бөгөөд тэнд тэрээр ариун хот Калиграмыг харлаа. Тэр хотод Дээд Бурхан Өөрийн Калешва дүрээр залардаг ажээ. Хотын ойролцоохон Годавари мөрний эрэгт нэн их өгөөмөр, дээд зорилго хийгээд Ведийн судар бичээсийн нууцыг ухварлан ойлгосон нэгэн цэвэр ариун брахман суух бөлгөө. Тэрээр өдөр бүр энэ газарт суун “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийн шүлгүүдийг давтан унших ажээ. Түүнийг хараад Индра Тэнгэр ихэд баярлан түүний бадамлянхуан өлмийд сөхрөн унаж, “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийг уншиж сурахад туслахыг хүсэн гуйв. Хэсэг хугацааны туршид “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийг давтан уншсан Индра Тэнгэр Вишнулокийн дээд байр сууринд хүрсэн билээ. Тэнд хүрээд тэрээр Индра хаан гэж байх цаг мөчдөө бусад сахиулсан тэнгэрүүдийн хамт амсаж байсан цэнгэл таашаал нь Вишнулокийн оронд цэнгэн суух жаргал цэнгэлтэй харьцуулахын аргагүй өчүүхэн болохыг мэдэв.

Хайрт Парвати минь ээ, энэ л учир шалтгаанаар аугаа их мэргэдүүд тусгайлан “Шримад Бхагавад гита”-гийн Арваннаймдугаар Бүлгийг давтан уншдаг бөгөөд тун хурднаар Бурхан Вишнугийн бадамлянхуан өлмийд хүрдэг билээ.

Энэхүү Гита-Махатмьяг сонссон хийгээд уншин судалсан ямар ч хүн өөрийн хураан хуримтлуулсан нүгэл хилэнцээс тун хурднаар ангижран салах бөгөөд харин маш их итгэл бишрэл дүүрнээр энэ сургаалыг дурсан санасан хүн бүр бүхий л төрлийн буянт үйл болон тахилга өргөл үйлдсэнээс ирэх үр дүнг хүлээн авч, энэ ертөнцийн бүх эд баялагаар

цэнгэн жаргасны дараагаар Бурхан Вишнугийн мөнхийн орноо хүрэлцэн очих болно.

ЗАРИМ ҮГИЙН ТАЙЛБАР

Шлок – шүлэг

Трансцендент- энэ материаллаг ертөнцийн гадна орших

Вайкунтхийн гаригууд – Бурханлаг мөнхийн гаригууд, үгчилвэл “түгшүүр үгүй” гэсэн утгатай

Ашрам- бясалгал ба йогоор хичээллэгчдийн амьдрах оромж, сууц

Претха-шарпа- үгчилвэл “хий үзэгдэл-могой” гэсэн утгатай. Могой дүрст хий үзэгдэл

Брахма-ракшас- урьд төрөлдөө брахман байгаад нүгэлт үйлийн эрхээр хүний мах идэгч мангасын дүрд хувирагч

Кальпа-орчлонгийн өдөр. Энэ нь дэлхийн 4300 000 000 жилтэй тэнцэнэ.

Вишнулока-Вишну бурханы гариг, өөрөөр хэлбэл Вайкунтхийн гариг гэсэн утгатай.

Шудра- Ведийн нийгмийн доод анги буюу ажилчин

Брахмачари-гэр бүлгүйгээр амьдрах бурханлаг амьдралын үе шат

Апсар-тэнгэрийн орны бүжигчин

Гандхава-тэнгэрийн орны дуучин

Чандала- нохойн махан идэштэн буюу ойртон хүрэхийн аргагүй тэр нэгэн

Йамааража- Орчлонгийн хэв журмыг сахиулагч тэнгэр, монголчууд “эрлэг номун хаан” гэдэг.

Йамадуг- Йамаараж тэнгэрийн элч зарлагууд, эрлэгийн элч нар

Брахман- ведийн нийгмийн хамгийн дээд анги давхаргын төлөөлөл, орчин үеийнхээр бол багш, эрдэмтнүүд

<http://www.veda.mn>

e-mail: bhadra_mon@yahoo.com